

### Агуулга

|      |   |    |
|------|---|----|
| 1.   | Төслийн товч тодорхойлолт   | 2  |
| 2.   | Төлөвлөгөөг гүйцэтгэх “Баруун Баруун Урт” уурхайн уулын ажлын төлөвлөлт, Байгаль орчны төлөв байдлын суурь нөхцөл     | 3  |
| 2.1. | “Баруун Баруун Урт” уурхайн уулын ажлын төлөвлөгөө  | 3  |
| 2.2. | Байгаль орчны төлөв байдлын суурь нөхцөл  | 17 |
| 3.   | Төлөвлөгөөний гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл   | 18 |
| 4.   | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тухай жилийн зорилт  | 20 |
| 5.   | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө  | 21 |
| 6.   | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө  | 27 |
| 7.   | Байгаль Орчны нөхөн сэргээлтийн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө   | 29 |
| 8.   | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө  | 29 |
| 9.   | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө  | 29 |
| 10.  | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө   | 30 |
| 11.  | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө  | 31 |
| 12.  | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр  | 32 |
| 13.  | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө             | 34 |
| 14.  | Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө | 35 |
| 15.  | Байгаль орчны менежментийн 2024 оны төлөвлөгөөний төсөв   | 42 |

### Хавсралт

Хавсралт зураг №1 Уурхайн байр зүйн зураг, “Баруун Баруун урт” алтны ил уурхайн 2024 оны масштаб 1:2000 ашиглалтын үйл ажиллагаа, БОНС-ийн төлөвлөлт

| №  | Нэр   | хуулбар | Хуудас |
|----|---|---------|--------|
| 1. | Аж ахуй нэгжийн гэрчилгээ   | +       | 43     |
| 2. | Ашиглалтын тусгай зөвшөөрөл MV-008097                               | +       | 45     |
| 3. | БОАЖЯ-ны кадастрын лавлагаа   | +       | 49     |
| 4. | ТЭЗҮ-ийн батлагдсан нүүр  | +       | 51     |
| 5. | БОНҮ-ний батлагдсан нүүр  | +       | 54     |
| 6. | Байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа төлсөн баримт               | +       | 60     |
| 7. | Уулын ажлын төлөвлөгөөний батлагдсан нүүр                           | +       | 61     |
| 8. | Уулын ажлын төлөвлөгөөний Маягт-10 Байгаль орчны нөхөн сэргээлт     | +       | 62     |
| 9. | УАТөлөвлөгөөний Маягт-14 Уулын ажлын төлөвлөгөөний зардлын задаргаа | +       | 63     |

### 1. Төслийн товч тодорхойлолт

“Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших Баруун Баруун уртын алтны шороон ордыг ашиглах төслийн үйл ажиллагааны явцад “Баруун Баруун Урт” алтны ил уурхайн 2024 онд гүйцэтгэх Байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөлт”...

Дээрхи ажлын хүрээнд өөрийн MV-08097 тусгай зөвшөөрөлтэй талбай дахь уурхайд 4.0 га-д техникийн, 4.0 га-д биологийн өссөн дүнгээр бүгд 8 га талбайд байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлыг хийнэ.

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-08097

Эзэмшигч: “Хунан” ХХК РД: 2549204

Төлөвлөлтийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралтын дагуу боловсруулав.

Компанийн товч танилцуулгыг хүснэгт №1-д үзүүлэв.

Хүснэгт №1

| д/д | Мэдээллийн төрөл   | Мэдээлэл оруулах багана   |
|-----|--|---|
| 1.1 | 1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэр                         | “Хунан” ХХК   |
|     | 2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар, (РД)          | 1411001082 (2549204)  |
|     | 3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл                 | Алт олборлолт   |
|     | 4. Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг                        | БГД дүүрэг 20-р хороо Өнөр хотхон 39-194  |
|     | 5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг               | Х.Бат-Эрдэнэ, утас: 99118411<br>erdenedorno_2020@yahoo.com  |
|     | 6. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг | Менежер Э. Эрдэнэсүвд, утас: 99065956<br>Ня-бо Э.Эрдэнэчимэг, утас: 91913769<br>Уул уурхайн инженер<br>С.Ганбат, утас: 94014243 |
| 1.2 | 1. Төслийн нэр   | “Баруун Баруун урт” ил уурхайн 2024 онд хэрэгжүүлэх БО-ны менежментийн төлөвлөгөө   |
|     | 2. Төслийн харьяаллын байршил                              | Төв аймаг Сэргэлэн сум 1-р баг  |

## 2. Төслийг гүйцэтгэх “Хунан” ХХК-ий “Баруун Баруун Урт” уурхайн уулын ажлын төлөвлөгөө, Байгаль орчны төлөв байдлын суурь нөхцөл

### 2.1. “Баруун Баруун Урт” уурхайн уулын ажлын төлөвлөгөө (товчилсон хэлбэрээр бичив)

**1. Ордын байршил районы физик газар зүй эдийн засгийн байдал:** “Хунан” ХХК-ийн эзэмшдэг MV-08097 дугаартай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөрөлтэй Баруун Баруун урт алтны шороон орд нь Улаанбаатар хотоос зүүн ургаш 80 км, Налайх дүүргээс зүүн урагш 34 км-т, Улаанбаатараас Замын-Үүдийн чиглэлийн хатуу хучилттай замаас зүүн зүгт 6 км зайд Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутагт оршино.

MV-08097 дугаартай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөрөлтэй талбайн байршилыг зураг №1, хэмжээ булангийн эргэлтийн цэгийн солбицлыг хүснэгт №2-д үзүүлэв.



Зураг №1 Талбайн байршлын зураг

Хүснэгт № 2

| №         | B      |       |        | L      |       |        | X            | Y           |
|-----------|--------|-------|--------|--------|-------|--------|--------------|-------------|
|           | градус | минут | секунд | градус | минут | секунд |              |             |
| 1         | 47     | 33    | 41.79  | 107    | 26    | 1.34   | 5270446.9293 | 683071.3284 |
| 2         | 47     | 33    | 41.78  | 107    | 25    | 1.34   | 5270407.4326 | 681817.6826 |
| 3         | 47     | 34    | 1.79   | 107    | 25    | 1.34   | 5271025.1225 | 681798.4398 |
| 4         | 47     | 34    | 1.79   | 107    | 26    | 1.34   | 5271064.3098 | 683051.9625 |
| S=77.48га |        |       |        |        |       |        |              |             |

**Физик газар зүй:** Баруун Баруун Уртын алтны шороон орд нь физик газарзүйн мужлалаар Хэнтийн мужийн захын уулсын тойргийн салбар уулсын өмнөд толгодорхог тал хээрийн бүсэд Жанчивлингийн рашаан сувилалаас баруун урд зүгт 13-17 км-т оршино.

Тус бүс нутагт жилийн хүйтэн үеийн үргэлжлэх хугацаа урт агаарын температурын жилийн болон хоногийн хэлбэлзлэл ихтэй хур тунадас харьцангуй бага хуурайдуу эх газрын эрс тэс уур амьсгалтай. 1-р сард хамгийн хүйтний үе ирдэг ба  $-23.8^{\circ}\text{C}$ , 7-р сард  $+21.0^{\circ}\text{C}$  орчим дундаж дулаантай байдаг байна. Агаарын температур зарим үед хэлбэлзэж  $+ - 40^{\circ}\text{C}$  дээш гардаг.

Баруун Баруун уртын ордын орчимд мөнхийн цэвдэг байхгүй улирлын чанартай 2-3 м гүн хөлддөг газар гэсэлт удаан байдаг.

Ордын талбайд гадаргуугийн болон хөрсний ус байхгүй. Олон жилийн дунджаар 224.8 мм хур тунадас ордог.

Энэ районд салхи ихэнхдээ баруун, баруун хойноос чиглэлтэй бөгөөд дундаж хурд нь гол төлөв 1-5 м/сек орчим байна.

**Эдийн засгийн байдал:** Эдийн засгийн хувьд тус районд хот суурин, зам харилцаа, эрчим хүчний хангамж сайн хөгжсөн. Буурлын давааны амнаас эхлээд баруун тийшээ Авдрантын массив хүртлэх 80 км хүртлэх орон зайд орших их бага хөндийнүүдэд алтны шороон ордын олон тооны илрэлтэй ба хоорондоо ойр орших хэд хэдэн жижиг ордууд нээгдэн ашиглаж байна.

“Хунан” ХХК-ийн Баруун Баруун-Урт алтны ил уурхай нь Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт оршдог учир орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүд, иргэдтэй зөв ойлгоцож хоорондын зөрчилгүй үйл ажиллагаа явуулж байна.

Төв аймгийн Сэргэлэн сум нь 1924 онд байгуулагдсан, хуучнаар Түшээт хан аймгийн Дархан гүний хошуу, Баян бүрд, Хайрхан, Хөшиг, Эрдэнэ-Уул, Авдар гэсэн 5 багийн нийт 670 өрхөд 1841 хүн амьдардаг. Хүн амын тоогоор Төв аймгийн 26 сумаас 17 -д, газар нутгийн хэмжээгээр эхний 5-д ордог.

Тус районд геологийн судалгааны ажил нилээд хожуу эхэлсэн ба анх 1980 онд Жанчивлангийн цагаан тугалганы эрэл-хайгуулын ажил гүйцэтгэж байгаад цохилтот өрмөөр алтны хуримтлал Баруун Уртын хөндийн аллюви-пролювийн хурдсанд тогтоосон байдаг.

Ордын районд орших аж ахуйн нэгжүүд, тэдгээрийн байнгын хэрэгцээтэй эрчим хүчийг төмөр замын 7-р зөрлөг, Жанчивлангийн рашаан сувилалын өндөр хүчдэлийн шугамаас хангадаг. Үүнтэй уялдан районы дэд бүтэц харилцаа холбоо харьцангуй сайн.

**2. Ордын геологийн тогтоц:** Баруун баруун уртын алтны шороон ордын геологийн тогтоц нь дөрөвдөгчийн настай /Q<sub>IV</sub>/ тунамал хурдас болох элсэнцэр, янз бүрийн хэмжээтэй хэмхдэс материал, хайрга дайрга бүхий шавранцрын үе давхаргуудаас бүрдэнэ.

Эдгээр хурдас нь дээд протерозой, доод кембрийн хурдсыг хучиж, угаагдсан гадаргуу дээр тогтоно. Эртний хувирмал, тунамал хурдсууд нь гидротермаль-метасомит болон гидротермаль гаралтай кварцийн /болорын/ нарийн судланцаруудаар зүсэгдсэн байдаг.

Баруун баруун уртын алтны шороон ордод малтсан малталтуудын зүсэлтээс харахад алтны давхарга агуулсан аллювал-пролювал хурдас нь цайвар саарал, дээд хэсэгтээ боровтор саарал өнгөтэй тои жижиг чулуулгийн хэмхдэс агуулсан байдаг. Алтны мөхлөгүүд нь ул чулуу болох занарын дээд хэсгээр, өгөршиж хэмхэрсэн ан цавуудаар нэвчиж орсон байдаг. Ордын нийт урт 1.4 км, өргөн 80-160м байдаг.

Баруун Баруун-Уртын алтны шороон орд нь геологийн тогтоц харьцангуйгаар жигд нэгэн төрлийн, ашиглалтын нөхцөл хялбар юм. Хөрсний ус байхгүй.

**3. Ордын хурдсын чанарын үзүүлэлт:** Баруун баруун уртын алтны шороон ордын геологи, геоморфологийн тогтоц, алтны тархалтын онцлог, ашигт давхаргын бүтэц, гидрогеологи, уул техникийн нөхцөл байдлыг хээрийн судалгааны ажил болон зэргэлдээ орших ордтой харьцуулж судалгааны ажил явуулсан.

Баруун Баруун-Уртын хуримтлалын тархалтын хүрээ нь 1400 м урт, 60 м дундаж өргөнтэй, алтны шороон ордын хуримтлал нь сэвсгэр хурдасны доод хэсэгт байрлах хайрган хурдастай холбоотойгоор 1.4 м-ийн гүнд 1.1 м-ийн дундаж зузаантай нэг давхаргыг үүсгэсэн тогтоцын хувьд энгийн байна.

Ашигт давхаргыг агуулагч сэвсгэр хурдас болох чулуулгийн хэлтэрхий, хэмхдэс бүхий улаан шавар маш багаар агуулсан хайрга, хайрганцарын хурдсанд хээрийн судалгаагаар шурф малталтын болон уурхайн олборлолтын явцад, шаварлаг материал, +100 мм-ээс дээш хэмжээний бул чулуу байхгүй бөгөөд суурь чулуу нь элсэн чулуу байгаа нь харьцангуй баяжигдах чанар сайн байна.

Баруун Баруун-Уртын алтны шороон орд нь харьцангуй дээр гүнд бус байрладаг, шаварлаг материал маш бага, хайрга, хайрганцар нь хялбар угаагдах чанартай, сэвсгэр хурдас болон ашигт давхарга нь усгүй, олон жилийн цэвдэг чулуулаг тархаагүй зэрэг уул техникийн харьцангуй сайн нөхцөттэй байна.

Дээжийн бодисын найрлагын судалгаа: “Ханлаб” ХХК-ий лабораторид ордыг төлөөлөх дээжийг +65, -65-с +45, -45-с +25, -25-с +19, -19-с +12.5, -12-с +8 мм, -8-с +2 мм гэсэн 7 фракцаар шигшэн ширхэглэл бүрээс дахин дээж авч тунгалаг шлиф бэлтгэн минераграфи, петрографийн шинжилгээ хийж гүйцэтгэсэн.

Эндээс бодисын найрлагын судалгааны дүгнэлт: Ордыг төлөөлөх дээжийг +65, -65-с +45, -45-с +25, -25-с +19, -19-с +12.5, -12-с +8 мм, -8-с +2 мм гэсэн 7 фракцаар шигшэн ширхэглэл бүрээс дахин дээж авч тунгалаг шлиф бэлтгэн минераграфи, петрографийн шинжилгээ хийж гүйцэтгэсэн. (хүснэгт №2-2)

Дээж нь бараан, хар саарал, улбар хүрэн туяатай цайвар саарал өнгөтэй, зурваслаг, занарлаг, линзлэг, нугалааслаг бичил цогцлолтой чулуулгуудаас тогтох ба петрографийн шинжилгээгээр дараах 4 төрлийн чулуулагаас зонхилон бүрдэж байна. Үүнд:

А. Карбонатчлагдаж, цахиуржсан, цахиурлаг- гялтгануурт бичил занар (65-70 %)

Б. Сулавтар төмөржсөн биотит -серицит-кварцат занар (15-20%)

В. Кварцын судал (5-10%)

Г. Метасоматоз хувирлаар хүчтэй хувирсан диорит порфир (Диорит порфиороор үүссэн альбит-серицитэт занар)-цөөн

Баяжмалд хийсэн шлихийн минералогийн шинжилгээгээр алт тодорхойлогдсон ба түүний хамт магнетит, ильменит, хромит, циркон, анатаз, барит, пирит, апатит, монацит зэрэг эрдсүүд бага хэмжээтэй тодорхойлогдсон байна.

Алт нь цайвардуу шаргал өнгөтэй, дунд зэргийн мөлгөржилттэй, зузаан, нимгэн хавтгай хэлбэр зонхилсон. Гадаргуу тэгш, цөөн мөхлөг арзгар гадаргуутай байлаа. Мөхлөгийн хэмжээ 0.1\*0.1 мм-с 0.4\*0.6 мм. Алтны сорьцыг химийн шинжилгээгээр 885 гэж тогтоосон болно.

**4. Ордын гидрогеологийн судалгаа:** Тус район хуурайвтар уур амьсгалтай. Жилийн дундаж харьцангуй чийгшлийн утга 69% орчим өвлийн улиралд агаар нэн хүйтэн ханасан төлөвтөө ойртох учраас харьцангуй чийгшил хамгийн өндөр хэмжээндээ 76-80% хүрэх ба хавар агаарын чийг агуулах чадвар нэмэгдээд ирэх үед хамгийн хуурай болох учир харьцангуй чийгшлийн хамгийн бага утга 54-57%. Харин зун хур борооны улирал эхэлхэд ахин бага зэрэг нэмэгдээд намар ахин багасна.

1980-1983 онд гидрогеологийн судалгаа хийсэн үр дүнгийн тайланд нилээд дэлгэрэнгүй тусгасан байдаг. Ордын талбай түүний орчны чулуулаг хурдсын геологийн бүтцээс шалтгаалан ус агуулагч 3 давхаргыг ялгасан байна. Томоохон хөндийнүүдийн аллювийн гаралтай сэвсгэр хурдас нь ус агуулах ба боржин чулууны ан цавын бүс түүний өгөршлийн хэсэгт усны 2-р давхарга мөн эрт төрмөлийн хувирмал хурдасны хагаралд орсон бүсийн ан цавын хэсэгт усны 3-р давхарга оршино. Ус агуулагч 1-р давхарга нь хайрга, элс, шавранцар, дайрга зэргээс тогтсон 2.0-3.5 м зузаантай сэвсгэр хурдасны дотор байрлах ба усжилтын хэмжээ нь гадаргуугийн хур тунадасны хэмжээнээс хамаарч улирлын чанартайгаар өөрчлөгдөж байдаг. Энэ уст давхаргын усжилт төдий л сайн биш.

Баруун-Уртын хөндийнүүдэд өрөмдсөн цооногт ан цавархаг үеийн зузаан нь 11.7-23.5 м, усны ундарга нь 1.0-13.0 л/сек бөгөөд уурхайн усан хангамжийн гол эх үүсвэр болж байна. Баруун-Уртын ордын талбай дээр хайгуулын 76-р шугамын орчинд 2012 онд өрөмдсөн хоёр, 100-р шугамын орчинд 2016 онд өрөмдсөн хоёр гүний усны худаг байрладаг. Эдгээр худгийн гүн нь 50м усны тогтсон түвшин нь 8-12м. ундарга нь 2.0л/сек-6.0л/сек ус агуулах зузаан нь 23.5 м гэсэн үзүүлэлтүүдтэй. Ордын олборлолтын техникийн усны хэрэгцээг эдгээр худганд түшиглэн хангахаар төлөвлөж байна.

**5. Ордын нөөцийн тооцоо:** 2024 онд олборлох Баруун Баруун уртын алтны шороон ордын блокуудын нөөцийг хүснэгт № 3-д үзүүлэв.

2024 онд олборлох блокуудын нөөц

(Сорьц 885) Хүснэгт №3

| Блокийн дугаар | Шугамын дугаар | Шурфын тоо | Дундаж зузаан, м |              | Дундаж агуулга, (шлихээр) мг/м <sup>3</sup> | Нөөцийн блокийн талбай, мян.м <sup>2</sup> | Эзлэхүүн, мян.м <sup>3</sup> |                | Алтны нөөц, кг   |                  | Хөрс хуулалтын коэффициент м <sup>3</sup> /м <sup>3</sup> |
|----------------|----------------|------------|------------------|--------------|---|--|------------------------------|----------------|------------------|------------------|---|
|                |                |            | Хучаас           | Элс          |   |  | Хучаас                       | Элс            | Шлих             | Хими цэвэр       |   |
| В-17           | 134-136        |            | 0.30             | 1.46         | 358   | 33.2390                                    | 9.9717                       | 48.5290        | 17.373372        | 15.375434        | 0.2   |
| В-18           | 136-138        |            | 0.00             | 1.47         | 524   | 0.1149                                     | 0.0000                       | 0.1689         | 0.088553         | 0.078369         | 0.0   |
| <b>Нийт В</b>  |                |            | <b>0.299</b>     | <b>1.460</b> | <b>0.359</b>                                | <b>33.3539</b>                             | <b>9.9717</b>                | <b>48.6979</b> | <b>17.461925</b> | <b>15.453803</b> | <b>0.2</b>  |

**6. Ордын уул-техникийн нөхцөл, ашиглах арга:** Ордын хэмжээнд хөрсний хурдас нь том бул чулуу, цэвдэгшил байхгүй, уул-геологийн нөхцөл харьцангуй энгийн тул олборлолтын явцад хүндрэл үүсэхгүй.

Энэ жилд ордын алтны дундаж агуулга 317 мг/м<sup>3</sup> (химийн цэврээр).

Алтны ширхэг жижиг, элсний угаагдах чанар сайн, техникийн болон ундны усны нөөцөөр бүрэн хангах боломжтой. Хурдсын сийрэгжилтийн коэффициент 1.4. Тоосжилтын хэмжээ их биш, алттай давхарга нь гүн суугдсан цүнхээл, үүр үүсгээгүй, улны цэвэрлэгээ, уурхайн ёроол гаргахад хүндрэл гарахгүй.

Элсийг экскаватор-автотээврийн хослолоор ил уурхайн аргаар ашиглах боломжтой бөгөөд олборлох хэсэгшлийн хөрсийг ашигласан хоосон орон зайд хийх боломжтой. Энэхүү шийдэл нь байгаль орчинд эергээр нөлөөлж нөхөн сэргээлтийн зардлыг бууруулах сайн талтай юм.

**7. Ил уурхайн хүрээ хязгаар:** Ил уурхайн хүрээ хязгаарыг ордын бодитой нөөцийн В-17 18-р блокуудыг хамарсан 3.33539 гектар талбайд олборлохоор загварчилсан.

**8. Ил уурхайн ашиглалтын технологи:** Ордын ашиглалтын гүн харьцангуй их биш уул-техникийн нөхцөл энгийн тул үүнээс хамааруулан ордыг ил уурхайн аргаар, автотээвэртэй ашиглалтын системээр ашиглахаар ТЭЗҮ-д тусгасан.

Экскаватороор дээд давхаргын 0.3 метр хүртэл дундаж зузаантай шимт хөрсийг хуулж уурхайн хил хүрээний гадна түр овоолгод хадгалж үндсэн хөрсийг дотоод овоолгод ашиглагдсан орон зайд байршуулахаар тооцсон. Алт агуулсан элсний давхаргыг экскаватор, автосамовалын хослолоор, угаан баяжуулах төхөөрөмж байрласан талбайд тээвэрлэн хүргэнэ.

Уурхайн ашиглалтын технологи

Хүснэгт №4

| Технологи                           | Үндсэн ажил   | Технологийн процессууд            |
|-------------------------------------|---------------|-----------------------------------|
| Авто тээвэртэй ашиглалтын технологи | Хөрс хуулалт  | Ухаж ачих<br>Тээвэрлэх<br>Овоолох |
|                                     | Элс олборлолт | Ухаж ачих<br>Тээвэрлэх<br>Овоолох |

Ордын ашиглалтын технологийн схем, тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтэд тулгуурлан ил уурхайн үндсэн параметруудийг сонгосон. Үүнд:

Доголын өндөр: Ордын хэмжээнд хөрс, элсний давхарга нь харьцангуй бага зузаантай, хайгуулын тайланд тусгагдсанаар хөрсний дундаж зузаан 0.3 м, элсний давхаргын дундаж зузаан 1.47 м тул нийт уурхайд дунджаар 1.77 м ухаш үүснэ.

Уурхайн доголын хажуугийн өнцгийг чулуулгийн тогтворжилтоос хамааруулан 60 градус, замын өргөнийг тухайн замаар явах тоног төхөөрөмжийн овор хэмжээнээс хамааруулан 7-8 м байхаар тус тус тооцсон. Ил уурхайн үндсэн хэмжээсүүд хүснэгт №5-д үзүүлэв

Хүснэгт №5

| № | Үзүүлэлт                           | Хэмжих нэгж | Утга      |
|---|------------------------------------|-------------|-----------|
| 1 | Ил уурхайн ажлын доголын өндөр     | м           | 3 хүртэл  |
| 2 | Доголын хажуугийн өнцөг            | градус      | 60        |
| 3 | Замын өргөн                        | м           | 7-8       |
| 4 | Автомашинны орц гарцын дагуу налуу | %           | 80 хүртэл |

**9. Ил уурхайн үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо:** 2024 онд олборлох блокууд дахь алтны нөөцөнд тулгуурлан, үйлдвэрлэлийн хаягдал, бохирдолтын хэмжээг дараах байдлаар тооцов.

Олборлолтын үеийн хаягдлыг ТЭЗҮ-ийн тооцоогоор 0 %.

Олборлолтын үеийн бохирдолтын хэмжээг ТЭҮ-ийн тооцсоны дагуу авав.

Ашиглалтын үеийн хаягдал: Олборлолтын гүн харьцангуй бага зэрэг бусад үзүүлэлтээс хамаарч 0% байхаар тооцов.

Ордын үйлдвэрлэлийн нөөцийн тооцоог хүснэгт №6-д үзүүлэв.

Баруун Баруун урт уурхайн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Ашиглалт явуулах В-16, 17-р блокуудын үйлдвэрийн нөөцийн тооцооны хүснэгт (сорьц 885)

Хүснэгт №6

| Блокын дугаар | ОЛБОРЛОЛТОД ӨРТӨХ ГЕОЛОГИЙН НӨӨЦ |             |                      |                      |                              |                |   | АШИГЛАЛТЫН ҮЕИЙН ХАЯГДАЛ, БОХИРДОЛ |                 |                 |              |               |               |                 |
|---------------|----------------------------------|-------------|----------------------|----------------------|------------------------------|----------------|---|------------------------------------|-----------------|-----------------|--------------|---------------|---------------|-----------------|
|               | Зузаан (м)                       |             | Дундаж агуулга мг/м3 | Блокын талбай мян.м2 | Эзлэхүүн, мян.м <sup>3</sup> |                | Алтны нөөц, кг (хими цэвэр) (сорьц 885) | ТЭЗҮ-р Бохирдол ∑28.2%, мян.м3     |                 |                 |              | Хаягдал, 0.0% |               |                 |
|               | Хөрс                             | Элс         |                      |                      | Хөрс                         | Элс            |   | Нийлбэр бохирдол                   | Тааз            | Ул              | Хажуу хана   | Элс, мян.м3   | Алт, кг       |                 |
|               |                                  |             |                      |                      |                              |                |   |                                    | тооцох          | тооцох          | тооцоолох    |               |               |                 |
| 14.00%        |                                  |             | 13.70%               |                      |                              | 0.50%          |   |                                    | 0.0%            |                 |              |               |               |                 |
|               | 8                                | 9           | 10                   | 11                   | 12                           | 13             | 14                                      | 18                                 | 19              | 20              | 21           | 22            | 23            | 24              |
|               | 8                                | 9           | 10                   | 11                   | (8*11)                       | (9*11)         | (13*10)* сорьц                          | (13-23)* 18 (%)                    | (13-23)* 19 (%) | (13-23)* 20 (%) | ∑(18-20)     | %             | 13*22 (%)     | (23*10)* сорьц  |
| В-17          | 0.30                             | 1.46        | 358.0                | 33.2390              | 9.9717                       | 48.5290        | 15.375434                               | 6.7941                             | 6.6485          | 0.243           | 13.69        | 0.0%          | 0.0000        | 0.000000        |
| В-18          | 0.00                             | 1.47        | 524.3                | 0.1149               | 0.0000                       | 0.1689         | 0.078369                                | 0.0000                             | 0.0000          | 0.000           | 0.00         | 0.0%          | 0.0000        | 0.000000        |
| <b>нийт В</b> | <b>0.15</b>                      | <b>0.99</b> | <b>317</b>           | <b>33.3539</b>       | <b>9.9717</b>                | <b>48.6979</b> | <b>15.453803</b>                        | <b>6.7941</b>                      | <b>6.6485</b>   | <b>0.2426</b>   | <b>13.69</b> | <b>0.0%</b>   | <b>0.0000</b> | <b>0.000000</b> |

Үргэлжлэл

| Магадлагдсан нөөцийн зэрэг | ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НӨӨЦ                |               |                |                      |                             | ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХАЯГДАЛ, БОРЛУУЛАХ МЕТАЛЛ       |                |  |                  |
|----------------------------|-----------------------------------|---------------|----------------|----------------------|-----------------------------|---|----------------|--|------------------|
|                            | Нэмэгдэх хөрс, мян.м <sup>3</sup> | Хөрс          | Элс            | Дундаж агуулга мг/м3 | Алтны нөөц, (хими цэвэр) кг | Үйлдвэрлэлийн хаягдал, 10 % кг (хими цэврээр) |                | Борлуулах металл 90.0% кг (хими цэврээр) |                  |
|                            |                                   | мян.м3        | мян.м3         |                      |                             | 10.00%  |                | 90.00%                                   |                  |
|                            | 26                                | 29            | 30             | 31                   | 32                          | 33  | 34             | 35                                       | 36               |
|                            | тооцоолох                         | (12-18+26)    | (13+21-27)     | 32/30                | (14-24+28)                  | %   | (32*33 (%))    | %  | (32*35 (%))      |
| В' - 17                    | 0.3281                            | 3.5058        | 62.2141        | 247                  | 15.375434                   | 10.00%  | 1.53754        | 90.00%                                   | 13.837891        |
| В' - 18                    | 0                                 | 0.0000        | 0.1689         | 672                  | 0.078369                    | 10.00%  | 0.00784        | 90.00%                                   | 0.070532         |
| <b>В'</b>                  | <b>0.3281</b>                     | <b>3.5058</b> | <b>62.3830</b> | <b>247.72</b>        | <b>15.453803</b>            | <b>10.0%</b>                                  | <b>1.54538</b> | <b>90.0%</b>                             | <b>13.908423</b> |

Тайлбар: В-17-р блокыг бүрэн олборлох учир олборлолтын технологи, уурхайн техникийн хил хязгаараар 18-р блокоос бага хэмжээний талбай авагдана.

2024 онд олборлох үйлдвэрлэлийн нөөцийн тооцоогоор хөрс хуулалтын коэффициент 0.22 м<sup>3</sup>/м<sup>3</sup> байна.



**10. Уурхайн хүчин чадал, ажиллах горим, ажиллах хугацаа:**

2024 онд уурхайд үйлдвэрлэлийн нөөцөөр дараах ажил хийгдэнэ. Үүнд:

|                                 |                            |
|---------------------------------|----------------------------|
| 1. Хөрс хуулалтын ажлын хэмжээ- | 3.5058 мян.м <sup>3</sup>  |
| 2. Элс олборлож баяжуулах-      | 62.3830 мян.м <sup>3</sup> |
| 3. Далан байгуулах:             | 2.29 мян.м <sup>3</sup>    |
| 4. Суваг татах                  | 0.83 мян.м <sup>3</sup>    |
| 5. Тунаах нуур цэвэрлэх         | 1.0 мян.м <sup>3</sup>     |
| Нийт:                           | 70.0088 мян.м <sup>3</sup> |

Уурхай нь дулааны улиралд (4-р сарын 15-наас 10-р сарын 15 хүртэл) 6 сарын хугацаанд жилд календарийн 181 хоног, хоногт 1 ээлж, ээлжинд 12 цагаар ажиллана.

Ажиллах горим, хугацаа, хүчин чадал:

|                           |   |
|---------------------------|---|
| Жилд ажиллах хоног-       | 181   |
| Засварт зогсох, хоног-    | 18  |
| Баяр ёслол, хоног-        | 7   |
| Болзошгүй саатлын, хоног- | 16  |
|                           | 181-41=140 хоног ажиллана.  |
| Хоногт ажиллах ээлж-      | 1   |
| Хоногт ажиллах цаг-       | 12  |
| Ээлжийн хүчин чадал -     | хөрс: 25.04 м <sup>3</sup> /ээлж<br>элс: 500.1 м <sup>3</sup> /ээлж |

**11. Ил уурхайд ажиллах тоног төхөөрөмжийн жагсаалт:** 2024 онд уурхайд ажиллах тоног төхөөрөмжийг уулын ажлын төлөвлөгөөнд тусгаснаар хүснэгт №8-д үзүүлэв.

Уулын үйлдвэрлэлийн процесст ажиллах техник тоног төхөөрөмжүүд

Хүснэгт №8

| № | Тоног төхөөрөмжүүд          | Үйлдвэрлэсэн улс | Марк             | Ширхэг | Үзүүлэлт                               |   | Нэгж үнэ сая.төг |
|---|-----------------------------|------------------|------------------|--------|--|---|------------------|
|   |                             |                  |                  |        | м <sup>3</sup> /цаг, м <sup>3</sup> тн | бүтээмж м <sup>3</sup> /цаг, м <sup>3</sup> /ээлж |                  |
| 1 | Угаах төхөөрөмж /скруббер / | Монгол           | M-60             | 1      | 60                                     | 60  | 65.0             |
| 2 | Экскаватор                  | Солонгос         | Hyundai 300 LC-7 | 1      | 1.5                                    | 660.0   | 200              |
| 3 | Экскаватор                  | Солонгос         | Doosan DX220     | 1      | 0.8                                    | 586   | 120.0            |
| 4 | Утгуурт ачигч               | БНХАУ            | ZL-50            | 1      | 3.0                                    | 656.0   | 84.2             |
| 5 | Автосамосвал                | БНХАУ            | FAW              | 2      | 25 тн                                  | 324.0   | 160.0            |
| 6 | Шатахууны машин             | солонгос         |                  | 1      | 2тн                                    | -   | 15               |
| 7 | Land Cruiser                | Япон             |                  | 1      |  |   | 75               |

**12. Баяжуулах хэсэг, технологийн бүдүүвч:** Алттай элсийг угааж баяжуулах технологи нь манай улсад нийтлэг хэрэглэгдэж буй гравитацийн аргаар хийгдэж байна.

Элсийг баяжуулахад Монголд үйлдвэрлэсэн скруббер MC-40 маркийн угаах төхөөрөмж нэгийг ажиллуулна.

Ордын алтны шигшүүрэн шинжилгээний үр дүнгээс харахад нарийн ширхэгтэй алт нилээд хувийг эзэлдэг. Алтны 16.6 % нь 0.25-0.16мм, 4.4 % нь 0.16мм-ээс бага ширхэгтэй.

Гравитацийн баяжуулалтаар алтны технологийн хаягдал 10 % хувь байхаар тооцоолов.

Уурхайгаас олборлосон алттай элсийг угаан баяжуулах Скруббер MC-40 маркийн төхөөрөмж нь зөөврийн (маневр) зориулалтаар тоногдсон 50 м<sup>3</sup>/цаг хүртэл бүтээмжтэй, хүрдэт эргэх торхны элс


шигших нүхнүүдийн хэмжээ нь  $\varnothing$ -8-18 мм, нам дүүргэлтийн үндсэн ба хяналтийн шлюзээр тоноглогдсон, металл авах зориулалтаар хялбарчлан холбогдсон подшлюз бүхий хослолтой юм. +18мм-ээс < дээш ширхэгтэй галь чулууны хаягдлыг үүсгэх ба -(8-18) мм ширхэгтэй материал нь шлюзээр дамжин хаягдал эфель, шлам бассейн, галь-ийг үүсгэнэ. Баяжуулалтаас гарсан хурдас дахь ашигт агуулгыг дээжлэлтээр шалгаж зарим хэсгийг дахин угаана.

Хаягдал эфиль, галь-ийг өмнө нь болон одоо эвдэгдсэн ухашуудад шууд утгуурт ачигчаар зөөвөрлөн хийж нөхөн сэргээлтийн эхний шатны ажлыг хийнэ.

Ахуйн болон цэвэр усны нуурын усан хангамжийг гүний худгаас ЭВЦ-6 маркийн хангах бөгөөд эргэлтийн тунаах нуураас 70-80% -ийг эргүүлэн ашиглана. Угаах төхөөрөмжийн усан хангамжийг эргэлтийн усан сангийн цэвэр нуураас ДНА (дизель насосная агрегат) төрлийн станцаар хангана.

Скрубберийг Hyundai D4BX хөдөлгүүрээр эргүүлнэ. МС-40 элс угаан баяжуулах төхөөрөмж нь цахилгаан болон цахилгаан эрчим хүчнээс үл хамааралтай дотоод шаталтат хөдөлгүүрээр ажиллах боломжтой юм.

Анхдагч түүхий эдийг экскавороор төхөөрөмжийн бункерт хийж өгнө. Баяжуулалтын технологийг гравитацийн аргаар явуулах бөгөөд химийн болон хортой бодис хэрэглэхгүй. Элс угаан баяжуулах ерөнхий схемийг зураг №2-т үзүүлэв.



Элс боловсруулалтын технологийн ерөнхий схем

**Гүйцээн баяжуулалт**



Зураг№2. Элс угаан баяжуулж боловсруулах технологийн ерөнхий бүдүүвч

**А. Баяжуулах цехийн хүчин чадал ажиллах горим:** 2024 онд үйлдвэрлэлийн нөөцөөр 62.383 мян.м<sup>3</sup> элс угаан баяжуулж 13.908423 кг (химийн цэврээр) алт борлуулахаар тооцоолов.

Элс угаан баяжуулах ажлыг орон нутгийн цаг агаарын байдлаас шалтгаалж 05-р сарын 15-с эхлүүлэн 10-р сарын 15 хүртэл 135-140 хоног 1 ээлжээр ажиллаж гүйцэтгэнэ.

**Б. Бүтээгдэхүүн боловсруулалт гаргалт:** Алттай элсийг угаах төхөөрөмж нь ил уурхайгаас ирэх анхдагч элсийг М-40 маркийн скрубберт угаан ангилж -20 мм; +20 мм-ийн ширхэглэлтэй болгож -20 мм-ийн ширхэглэлтэй хэсгийг хоригт цорго руу, +20 мм-ийн ширхэглэлтэй хэсэг нь галь болон гарна.

Хоригт цоргын баяжмалыг гүйцээн баяжуулах цехэд дахин ялган шлихын алтны баяжмал гарган авах бөгөөд бүтээгдэхүүн гаргалтыг хүснэгт №9-д үзүүлэв.

**Нийт бүтээгдэхүүн боловсруулалт гаргалт**


Хүснэгт №9

| № | Үзүүлэлт                              | Нэгж                    | 2024 он |
|---|---------------------------------------|-------------------------|---------|
| 1 | Нийт баяжуулах элс                    | мян.м <sup>3</sup> /жил | 62.383  |
| 2 | Элсэн дэх алтны агуулга               | гр/м <sup>3</sup>       | 0.25    |
| 3 | Элсэн дэх алтны хэмжээ (хими цэврээр) | кг                      | 15.45   |
| 4 | Баяжмалын гарц                        | %                       | 0.01    |
| 5 | Баяжмал дахь алтны агуулга            | гр/м <sup>3</sup>       | 2229.52 |
| 6 | Металл авалт                          | %                       | 90.0    |
| 7 | Борлуулах алт (хими цэвр)             | кг/жил                  | 13.91   |

**В. Элс баяжуулах хэсгийн хаягдлын сан:** Уурхайд баяжуулалтын үед химийн болон бусад хорт бодис хэрэглэдэггүй тенологийн хорт хаягдал гарахгүй. Харин гравитацийн баяжуулалтаас гарах хаягдал галь, эфил, шлам зэрэг нь тухай бүрийн уулын ажлын үйл ажиллагаатай уялдан уурхайн ухашийн дүүргэлт зэрэг ажилд нөхөн сэргээлтийн технологийн дагуу хэрэглэгдэнэ. Ахуйн болон механизмуудаас гарах хог хаягдал уурхайн тосгонд байгуулсан хогийн цэгт хаягдана.

Энд өмнө нь олборлосон нөхөн сэргээгдээгүй ухаш болон нуурыг дахин сэргээж ТЭЗҮ-д төлөвлөсний дагуу хаягдлын санг байгуулна. Энд гарах зардал нь их биш учир урсгал зардалд орно.

Булинга хуримтлуулах сангийн урт, өргөний хэмжээ 150 \* 96м, гүн нь 3-5м байх 4 бассейн дамжин эргэж байна байна. Хаягдлын сангийн 27 мян.м<sup>3</sup> булинга, тунаах эргэлтийн усан санг 16.3 мян.м<sup>3</sup> цэвэршүүлсэн ус орохоор эзлэхүүнийг тооцоолов. Далан нь орон нутгийн газрын элс хайрга, шавраар бүрдсэн овоолго байна. Далангийн бусад хэсгийг хайрга болон зориулалтын материалаар бэхжүүлж босгоно. Хаягдлын сангийн суурийг бэлтгэхдээ сонгосон талбайн хайрганы холимгоор хучиж нягтаршуулна. ТЭЗҮ-д төлөвлөгдсөн байдлаар хаягдлын сангийн зураглалыг зураг №3-т үзүүлэв.



Зураг№3 Хаягдлын сангийн зураг

Хүснэгт№10

| № | Үзүүлэлт                   | Нэгж                    | 2023 он |
|---|----------------------------|-------------------------|---------|
| 1 | Нийт угаан баяжуулах элс   | мян.м <sup>3</sup> /жил | 62,38   |
| 2 | Элсэн дэх алтны агуулга    | гр/м <sup>3</sup>       | 0.25    |
| 3 | Хаягдал дахь алтны агуулга | гр/м <sup>3</sup>       | 0.03    |
| 4 | Хаягдлын гарц              | %                       | 99.999  |
| 5 | Хаягдалд металл алдалт     | %                       | 10      |
| 6 | Хаягдал гаргалт            | мян.м <sup>3</sup> /жил | 62.38   |
| 7 | Хаягдал дахь алтны хэмжээ  | кг/жил                  | 1.55    |

Г. Угаан баяжуулах цехийн машин, тоног төхөөрөмж: Алт агуулсан элсийг угаан баяжуулах тоног төхөөрөмж Монгол улсад үйлдвэрлэсэн Скуббер М-40 маркийн гравитацийн угаах төхөөрөмж, Уг төхөөрөмж нь угаан ангилах, баяжуулах хэсгүүдээс бүрдэнэ. (Хүснэгт №11)

- Тэжээл өгөлтийн хүчин чадал:  $Q = 34-40 \text{ м}^3/\text{цаг}$
- Хэлбэлзлийн коэффициент: 1.1%
- Угаах төхөөрөмжийн суурилагдсан хүчин чадал:  $40.0 \text{ м}^3/\text{цаг}$
- Хэрэглэгдэх угаах төхөөрөмжийн тоо:

Угаах төхөөрөмжийн техникийн үзүүлэлт

Хүснэгт №11

| №  | Үзүүлэлт                                     | Хэмжих нэгж  | Тоон утга   |
|----|--|--|-------------|
| 1  | Тоног төхөөрөмжийн марк                      | -  | МС-40       |
| 2  | Хүчин чадал                                  | м <sup>3</sup> /цаг                                  | 40          |
|    | 1м <sup>3</sup> чулуулгийг угаах усны хэмжээ | м <sup>3</sup>                                       | 3.5-4       |
| 3  | Бункерын хэмжээ                              | L*W*H, м   | 3.5*2.5*1.8 |
| 4  | Эргэх торхны торны нүхний хэмжээ             | мм   | 18*18       |
| 5  | Ширхэглэлийн хэмжээ                          | мм   | 250         |
| 6  | Торхыг эргүүлэх хөдөлгүүрийн марк            | HYUNDAI D4BX   |             |
| 7  | Скрубберийн удирдлага                        | Гидравлик, гидро редуктор, араат гинжин дамжуулгатай |             |
| 8  | Түлш зарцуулалт                              | г/кВт.цаг  | 160         |
| 9  | Хөдөлгүүрийн чадал                           | кВт  | 55-59       |
| 10 | Түлшний бак                                  | л  | 180         |
| 11 | Маслын бак                                   | л  | 100         |
| 10 | Хоригт цорго (шлюз)                          | L*W*H, м   | 4*1.8*0.08  |
| 11 | Скрубберийн металл авалт                     | %  | 92 хүртэл   |
| 12 | Усны насосын марк                            | -  | ДНА-150     |
| 13 | Хэрэглэгдэх тоо                              | ширхэг   | 1           |



Д. Баяжуулах цехэд ажиллах машин техник: Ил уурхайгаас олборлосон алт агуулсан элсийг баяжуулах цехийн дэргэд түр овоолгод байрлуулан экскаватораар хүлээн авах бункерт хийж даралттай усан буугаар шүршин элсийг угаан ангилж, дараа нь анхан шатны баяжуулалтын төхөөрөмжөөр дамжиж угаагдсаны дараа гар аргаар металлыг ялгана. ZL-50 маркийн утгуурт ачигчаар баяжуулах цехээс гарсан галь, эфелийг түрж овоолох, овоолсон хаягдал чулуулгийг автосамосвалд ачиж ил уурхайн орон зайд асгаж техникийн нөхөн сэргээлтийн ажил зэргийг хийж гүйцэтгэнэ. ZL-50маркийн утгуурт ачигчийн техникийн үзүүлэлт

Хүснэгт №12

| № | Үзүүлэлтүүд           | Хэмжих нэгж       | Тэмдэглэгээ | Тоон үзүүлэлт |
|---|-----------------------|-------------------|-------------|---------------|
| 1 | Утгуурын багтаамж     | м <sup>3</sup>    | E           | 3             |
| 2 | Эргэлтын радиус       | м                 | r           | 6.1           |
| 3 | Ачих хамгийн их өндөр | м                 | h           | 3.1           |
| 4 | Явах ангийн урт       | м                 | E           | 6.3           |
| 5 | Явах ангийн өргөн     | м                 | I           | 2.7           |
| 6 | Их биений өндөр       | м                 | H           | 3.5           |
| 7 | Хөдөлгүүрийн чадал    | морь.хүч/кВт      | W           | 220/162       |
| 8 | Жин                   | тн                | m           | 16.5          |
| 9 | Түлш зарцуулалт       | гр/цаг.морины хүч | Q           | 165           |



Зураг №3. Утгуурт ачигч ZL-50

### **13. Дэд бүтэц, инженер хангамж:**

**А.Барилга байгууламжийн ерөнхий төлөвлөгөө:** Уурхайн барилга байгууламжид захиргааны байр, ажилчдын болон хоолны байр багтах бөгөөд эдгээр нь уурхайн баруун урд талд байрлана.

Барилга, байгууламж, хийц бүтэц

Хүснэгт №13

| № | Нэр                     | Хийц бүтэц                        | Тоо хэмжээ, ш |
|---|-------------------------|-----------------------------------|---------------|
| 1 | Захиргаа, ажилчдын байр | Байшин,<br>Зөөврийн<br>байгууламж | 4             |
| 2 | Хоолны газар            |                                   | 1             |
| 3 | Халуун усны байр        |                                   | 1             |
| 4 | Засварын байр           |                                   | 1             |
| 5 | Агуулахын байр          |                                   | 1             |

**Б. Машин техник, тоног төхөөрөмжийн завсар үйлчилгээ:** Тус уурхайн тоног төхөөрөмжийн засвар, техникийн үйлчилгээний газар нь тоног төхөөрөмж, авто тээврийн болон бусад тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахын тулд урсгал засвар, техникийн үйлчилгээ хийх, ашиглалт засварын хэрэгцээнд зориулсан материал, сэлбэг, тос, түлш зэргийг хүлээн авах, хадгалах, тавьж олгох зэрэг ажлыг гүйцэтгэж байсан талбайг үргэлжлүүлэн ашиглана.

Тоног төхөөрөмжийн их засвар, зарим нарийн төвөгтэй эд ангийг сэргээх, бүрэн солих зэрэг ажлыг засварын дагнасан газраар буюу тоног төхөөрөмжийг нийлүүлсэн газрын засварын газраар гүйцэтгүүлэнэ. Засварын цех-д өрөм, точиль, гагнуурын аппарат зэрэг тоног төхөөрөмжүүдийг байрлуулна.

**В. Шатах тослох материалын агуулах:** ШТМ хадгалахад зориулж 20 тн-ын ган сав 1ш, тос тосолгооны материалуудыг зориулалтын савтай нь хадгалан хэрэглэхээр төлөвлөв. ШТМ-ын агуулахыг гал, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын норм дүрмийн дагуу байрлуулан, зориулалтын тоноглолоор хангасан байгаа

**Г. Уурхай ба хотхоны цахилгаан хангамж** “Хунан” ХХК-ийн Баруун баруун уртын алтны шороон ордын ил уурхайд дараах хэрэглэгчид цахилгаан эрчим хүчээр тэжээгдэнэ. Үүнд гэрэлтүүлгүүд, ус шахах насос, хотхон, засварын талбай зэрэг хэрэглэгч орно. Угаах төхөөрөмж болон эргэлтийн усны насосууд нь өөр дээрээ суурьлагдсан дизель хөдөлгүүртэй тул холбогдох хэсгүүдэд тооцлоо. Баруун баруун уртын алтны шороон ордын ил уурхай нь төвлөрсөн цахилгаан

хангамжаас алслагдсан тул зөөврийн дизель станцаас цахилгаан эрчим хүчээ хангахаар төсөлд тусгав.

Д. Технологийн усан хангамжийн тооцоо Уурхайн усан хангамжийг гүний худгийн усаар хангана. Худгуудын байршлын солбицол UTM тусгалын тогтолцоонд: Худгийн цооног №1 X=5270441.8318, Y=682474.1444, №2 X= 5269459.9248, Y= 685003.7877, №3 X= 5269721.3850, Y= 684788.1690 байна. Худгууд бүгд паспорттой. Олон худаг байгаа нь олборлолт, нөхөн сэргээлт хийх, орон нутгийн малчдын ахуйн хэрэглээ, малыг услахад аюулгүй байдлыг хангах үүднээс ээлжлэн сэлгэж ашигладаг. Худгуудад ЭЦВ-6 маркийн гүний насос суурилуулсан. Худгууд дизель цахилгаан үүсгүүрээс цахилгаан энерги авч ажиллана. Худагууд 11л/сек ундрагатай.

Эргэлтийн цэвэр усны усан сангаас баяжуулах төхөөрөмж рүү дизель насосны агрегат (ДНА) төрлийн 1Д250-125 насосоор шахаж 150мм-ийн голчтой 100-150м урт уян синтетик хоолойгоор хүргэнэ.

Угаах төхөөрөмжөөс гарсан шламтай усыг сувгаар эргэлтийн усны тунаах нууранд хуримтлуулж 3.0-4.5 м өндөртэй, 25-30 м урттай хайрган шүүлтүүрээр шүүж тунгаагаад 200-300мм-ийн голчтой ган хоолойгоор дамжуулж цэвэр усны нөөцийн нууранд өгнө.

Ордын баяжмалтай элс угаагдах чанараар сайн зэрэглэлд хамаарагдана. 1м<sup>3</sup> баяжмал дахь элсийг усны хүчээр задалж алтны мөхлөгүүдийг чөлөөт байдалд оруулахад ТЭЗҮ-ний дундаж зарцуулалт 4м<sup>3</sup> ус хэрэглэх тооцоо байна. 2024 оны үйлдвэрлэлд 62383 м<sup>3</sup> элс угаана.

Элсийг баяжуулахад 62383 м<sup>3</sup> х 4 м<sup>3</sup> = 249532 м<sup>3</sup> ус шаардагдана. Ажиллах үеийн угаах төхөөрөмжийн усны дээрхи хэрэгцээг хангахын тулд уурхайн худагнуудаас 25%-ийг сэлбэж 75% -ийг эргүүлж ашиглана.

Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцвол:

Техникийн хүчин чадлаар тооцоход:

|  |   |
|--|---|
| 60 м <sup>3</sup> * 10 цаг/хоног = 600 м <sup>3</sup> /хоног                             | - Хоногт угаах элсний хэмжээ                    |
| 600 м <sup>3</sup> /хоног * 4м <sup>3</sup> /м <sup>3</sup> = 2400 м <sup>3</sup> /хоног | - Хоногт шаардагдах усны хэмжээ                 |
| 2400 м <sup>3</sup> /хоног * 4 хоног = 9600 м <sup>3</sup>                               | - Эргэлтийн усан санд тогтмол байх усны хэмжээ  |
| 62383 м <sup>3</sup> : 600 м <sup>3</sup> /хоног = 104 хоног                             | - Элс угаахад шаардагдах хоног                  |
| 2400 м <sup>3</sup> /хоног * 0.2 * 104 хоног = 49920 м <sup>3</sup>                      | - Ууршилт шүүрэлтээр алдагдах нийт ус           |
| 9600 м <sup>3</sup> + 49920 м <sup>3</sup> = 59520 м <sup>3</sup>                        | - Технологид хэрэглэх нийт усны хэмжээ          |
| (40000 м <sup>2</sup> * 4л/м <sup>2</sup> * 6 удаа)/1000=960 м <sup>3</sup>              | - Биологийн нөхөн сэргээлтэд ашиглах ус         |
| 500 ш мод * 45 л/ш * 8 удаа = 180 м <sup>3</sup>   | - “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд мод услах ус |
| 6314 м <sup>2</sup> * 5л/м <sup>2</sup> * 100 хоног = 3157 м <sup>3</sup>                | - Зам талбайн тоосжилт дарах                    |
| 15хүн * 150л/хоног * 181хон.= 407м <sup>3</sup> /жил                                     | - Жилийн, унд ахуйд хэрэглэх нийт усны хэмжээ   |

Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу төлбөр оногдуулах усны хэмжээ

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1 дэх заалтын дагуу ажилчдын унд ахуйн зориулалтаар ашиглах 407 м<sup>3</sup> газрын доорхи усыг төлбөрөөс чөлөөлнө.

Ашигт малтмал олборлон баяжуулахад ашиглах 59520 м<sup>3</sup>, зам талбайн тоосжилт дарах 2160 м<sup>3</sup>, биологийн нөхөн сэргээлт, мод услахад 1140 м<sup>3</sup> ус хэрэглэнэ. Газрын доорхи усны төлбөрийн хэмжээг “Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах” тухай Монгол улсын Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолд заасан суурь үнэлгээ, 2013 оны 327, 326 дугаар тогтоолд заасан ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тус тус үндэслэн урьдчилсан байдлаар тооцвол:

Ашигт малтмал олборлох, баяжуулахад усны нөөц ашигласны төлбөр:

$$1 \text{ м}^3 \text{ газар доорхи усны үнэ: } 2835 \text{ төг./м}^3 * 0.35 * 1.4 = 1389.15 \text{ төг./м}^3$$

Энд: 2835 төгрөг/м<sup>3</sup> - Хэрлэн голын сав газарт газар доорхи ус ашигласан нөхцөлд экологи, эдийн засгийн суурь үнэлгээ

35% - Засгийн газрын 2022 оны 416 дугаар тогтоолын 7(в)-д заасан газрын доорхи ус ашигласныг тооцох заасан хувь, хэмжээ

1.4 - Ашигт малтмал олборлох, баяжуулах үед газрын доорхи ус ашигласан нөхцөлд тооцох ашиглалтын зориулалтын итгэлцүүр

$$59520 \text{ м}^3 * 1389.15 \text{ төг./м}^3 = \mathbf{82682208 \text{ төг.}}$$

Зам, талбайн тоосжилт дарахад усны нөөц ашигласны төлбөр:

$$1 \text{ м}^3 \text{ газар доорхи усны үнэ: } 2835 \text{ төг./м}^3 * 0.2 * 0.3 = 170.1 \text{ төг./м}^3$$

Энд: 2835 төгрөг/м<sup>3</sup> - Хэрлэн голын сав газарт газар доорхи ус ашигласан нөхцөлд экологи, эдийн засгийн суурь үнэлгээ

20% - Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 4-д заасан хувь, хэмжээ

0.3 - Авто зам, засварт газрын доорхи ус ашигласан нөхцөлд тооцох ашиглалтын зориулалтын итгэлцүүр

$$3157 \text{ м}^3 * 170.1 \text{ төг./м}^3 = \mathbf{5370056 \text{ төг.}}$$

Биологийн нөхөн сэргээлтэд газрын доорхи усны нөөц ашигласны төлбөр:

$$1 \text{ м}^3 \text{ газар доорхи усны үнэ: } 2835 \text{ төг./м}^3 * 0.1 * 0.25 = 70.875 \text{ төг./м}^3$$

Энд: 2835 төгрөг/м<sup>3</sup> - Хэрлэн голын сав газарт газар доорхи ус ашигласан нөхцөлд экологи, эдийн засгийн суурь үнэлгээ

10% - Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 9-д заасан хувь, хэмжээ

0.25 - Ногоон байгууламжийн усалгаанд газрын доорхи ус ашигласныг тооцох итгэлцүүр  
(960м<sup>3</sup> + 180 м<sup>3</sup>) \* 70.875 төг./м<sup>3</sup> = **80797.5 төг.**

Нийт төлбөрийн хэмжээ:

**82682208 төг. + 537006 төг. + 80797.5 төг. = 8330001165 буюу 83.3 сая төг.** болж байна.



## 2.2. Байгаль орчны төлөв байдлын суурь нөхцөл

Газрын гадарга: Талбай орчим нь бүхэлдээ хээрийн бүсэд хамаарах бөгөөд харьцангуй нам газар юм. Энэ орчимд хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс дээш 1670 орчим м өндөрт өргөгдсөн уул нуруудтай бол хамгийн нам нь 1480 м юм. Гуу жалга цөөнгүй тохиолдоно.

Уур амьсгал: Тус бүс нутгийн зүүн хойд хэсэг буюу Хан Хэнтийн нуруу, түүний салбар уулст жилдээ 300 мм-с их хур тунадас унадаг бөгөөд урагшлах тусам хур тунадасаны хэмжээ багасдаг. Жилд унах тунадасны дийлэнх нь буюу 81-93% нь дулааны улиралд, 7-19% нь хүйтний улиралд ордог. Өөрөөр хэлбэл хамгийн их хур тунадас 6, 7, 8 дугаар сард, хамгийн бага нь 12, 1, 2 дугаар сард ордог. Тус аймагт бороотой өдрийн тоо жилд дунджаар ихэнхи нутагт 31-44 байдаг.

Цасан бүрхүүлийн зузаан, нягт зэрэг нь тухайн орон нутгийн хотгор, гүдгэр, салхины байдлаас хамаарч жигд биш байхаас гадна арилах хугацаа нь газар бүрт харилцан адилгүй. 9 дүгээр сарын 3 дугаар 10 хоногт анхны цас 5 дугаар сарын 1 дүгээр 10 хоногийн эцсээс 2 дугаар 10 хоногийн эцэст сүүлчийн цас ордог. Зарим жилд 8 дугаар сарын сүүлчээр эсвэл 10 дугаар сарын дунд үед анхны цас, 4 дүгээр сарын 11-27, эсвэл 6 дугаар сарын 19-22 нд эцсийн цас ордог байна. Тус аймгийн ихэнх нутгаар 10 дугаар сарын сүүлчээр цасан бүрхүүл тогтож, 4 дүгээр сарын сүүлээр арилдаг. Олон жилийн дунджаар цасан бүрхүүлийн зузаан 5-10 см, уулархаг нутгаар 6-12 см, бусад нутагт 3-5 см байдаг.

Хөрс, ургамал: Баруун Баруун уртын алтны шороон ордын талбайд хүрэн хөрс тархана. Хүрэн хөрс нь цайвар хүрэн хөрснөөс харьцангуй үржил шимтэй ба, хар хүрэн хөрснөөс үржил шимийн хувьд доогуур байдаг. Хүрэн хөрсний ерөнхий тархалтын зүй тогтол нь тархалтын хувьд урд зах буюу завсарын бүсэд тогтворжиж, үетэн өвс, үетэн хялгант, агь голлосон ургамлын эвшлийн доор үүснэ.

Ус зүй: Тухайн талбай нь гидрогеологийн нөхцлөөр Хэнтийн салбар уулсын номхон далайн ай савд хамаарах мужийн Хэрлэн голын усны сүлжээнд багтдаг бөгөөд гадаргуугийн байнгын урсацгүй уул хоорондын хоолойд оршино.

Баруун Баруун уртын хөндий нь тэвш хэлбэрийн хөндий ба хур бороо ихтэй ялангуяа ширүүн аадар бороо орох, хаврын шар усны үерээр түр зуурын урсгал үүсгэн шингэж алга болно.

Үндэсний атласт улирлын дунд зэрэг тэжээлтэй мужид орох ба гидрогеологийн хувьд Монголын төв хэсэгт багтан газрын доторх эрдэсжилтээр 0.5-1.0 г/л бүхий бүсийн заагт хамаарагддаг. Нутгийн хэмжээнд гол горхи, нуур тойром, булаг шанд зэрэг байгалийн илрэл муутай, өрөмдмөл гар худаг олон боловч эвдэрч орхигдсон байх нь цөөнгүй.

Талбайн хойд хэсгээр инженер-геологи, гидрогеологийн судалгаа харьцангуй сайн хийгдсэн. Ерөнхийдөө тус талбайн гадаргын болон газар доорх усаар муу, тэжээл авах нөхцөл сайнгүй бүс нутаг юм.

Хүн ам, эдийн засаг: Төв аймгийн нутаг дэвсгэр Монгол улсын төвийн бүс нутагт байрладаг. Сэлэнгэ, Хэнтий, Говьсүмбэр, Дундговь, Булган, Өвөрхангай зэрэг аймгуудтай хил залгаа оршино.

Нийт 74.8 мянган хавтгай дөрвөлжин км газар нутагтай. Төв аймагт 88.8 мянган хүн оршин сууж байна. Аймагт 1 км<sup>2</sup> нутагт 0.8 хүн ноогдож байгаа нь улсын дундаж (1.5)-аас 0.7 пунктээр бага байгаа хэдий ч хүн амын нягтрал харьцангуй ихтэй аймгуудын тоонд ордог.

Аймгийн нийт хүн амын 63.69 хувь нь буюу 56347 нь хөдөлмөрийн насны хүн ам юм. Үүний 43648 (77.46 %) ажиллагсад байна.

## 3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт: “Баруун Баруун урт” уурхайн алт олборлох төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд дурдсанаар газрын хэвлийг эвдэж өнгөн хөрс хуулах, карьер нээх, овоолго хийх, олборлох, тээвэрлэх, ангилан ялгаж угаах үйл ажиллагаагаар байгаль дэлхий эвдэрч бохирдохоос гадна тоос,

угаа гэх мэт агаарт дэгдэх, шатах, тослох материал болон шингэн хаягдал хөрсөнд нэвчих замаар бохирдол үүсч эко системд их бага болон болзошгүй сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Бохирдлын эх үүсвэр нь шороон авто зам, ангилж угаах процесс, түлш шатахууны агуулах, бохирын цэг, хатуу хог хаягдал, ахуйн химийн бодис (тоос, бохир ус, угаалгын нунтаг, саван, шампунь) зэрэг болно. Энд: БОНБНУ-ий тайлангаас авав.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тодорхойлноор:

Ашигт малтмал олборлох, уул уурхайн үйлдвэрлэл явуулах үед байгаль орчны төлөв байдал, орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлж болох нөлөөллийн үргэлжлэх хугацаа, түүний эрчимшил зэргийг тодорхойлоход магадлан жагсаах аргыг хэрэглэсэн байна.

Энэ арга нь ил аргаар алт олборлох үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг бөгөөд хэрэв тухайн нөлөөлөл байвал “х”- ээр тэмдэглэгдсэн.

Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах байдлыг хүснэгтээр үзүүбэл

Хүснэгт №15

| №   | Нөлөөллийн төрөл  | Хэлбэр |          | Хугацаа |     | Нөлөөллийн эрчим |                    |                     |        |            |          |
|---|---|--------|----------|---------|-----|------------------|--------------------|---------------------|--------|------------|----------|
|   |   | Шууд   | Шууд бус | Богтно  | Урт | Буцаж нөлөөлөх   | Буцалтгүй нөлөөлөх | Өөрөө зохицуулагдах | Хүчтэй | Дунд зэрэг | Сулавтар |
| 1. Байгаль орчин, экосистемийн өөрчлөлт   |   |        |          |         |     |                  |                    |                     |        |            |          |
| 1   | Газрын доорх усны урсац өөрчлөгдөх  |        |          |         |     |                  |                    |                     |        |            | x        |
| 2   | Гадаргын усны урсац өөрчлөгдөх  |        |          |         |     |                  |                    |                     |        |            |          |
| 3   | Ургамлан нөмрөг өөрчлөгдөх  | x      |          | x       |     | x                | x                  |                     |        | x          |          |
| 4   | Хөрсний элэгдэл, эвдрэл ихсэх   | x      |          | x       |     |                  | x                  |                     |        | x          |          |
| 5   | Геологийн тогтоц өөрчлөгдөх   | x      |          |         | x   |                  |                    |                     | x      |            |          |
| 6   | Зэрлэг ан амьтдын байршилт, тархалт өөрчлөгдөх  | x      |          | x       |     |                  | x                  | x                   |        |            | x        |
| 7   | Уур амьсгал(бичил)-ын өөрчлөлт  |        |          | x       |     |                  | x                  | x                   |        |            | x        |
| 2. Байгалийн нөөцийн ашиглалт   |   |        |          |         |     |                  |                    |                     |        |            |          |
| 8   | Эрдэс түүхий эдийн нөөц хомсдох   | x      |          |         |     |                  |                    |                     |        | x          |          |
| 9   | Бэлчээрийн талбай хомсдох   | x      |          |         | x   | x                |                    | x                   |        | x          |          |
| 10  | Үйл ажиллагаанаас усны нөөц хомсдох   | x      |          |         |     |                  |                    |                     |        |            |          |
| 11  | Ахуйн зориулалтаар ашигласнаас усны нөөц хомсдох  | x      |          |         |     |                  |                    |                     |        |            |          |
| 12  | Эрчим хүчний хэрэглээ нэмэгдэх /үйлдвэрийн хэрэгцээнд/  | x      |          |         |     |                  |                    |                     |        |            | X        |
| 13  | Эрчим хүчний хэрэглээ нэмэгдэх /ахуйн хэрэгцээнд/   | x      |          |         | x   |                  |                    |                     |        | x          | X        |
| 3. Байгаль орчны чанарын өөрчлөлт   |   |        |          |         |     |                  |                    |                     |        |            |          |
| 14  | Газрын доорх усны чанар өөрчлөгдөх  |        | x        |         | x   |                  | x                  |                     |        |            | x        |
| 15  | Гадаргын усны чанар өөрчлөгдөх  |        | x        |         |     | x                |                    |                     |        | x          |          |
| 16  | Агаарын бохирдол үүсэх  | x      |          |         |     |                  |                    |                     |        | x          |          |
| 17  | Хөрсний бохирдол үүсэх  |        | x        | x       |     |                  | x                  |                     | x      |            |          |
| 18  | Дуу чимээ, доргио чичиргээний нөлөөлөл  | x      |          | x       |     | x                |                    |                     | x      |            |          |
| 4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор |   |        |          |         |     |                  |                    |                     |        |            |          |
| 19  | Байгалийн унаган төрх болон ландшафтын хэлбэр төрх өөрчлөгдөх   | x      |          |         |     |                  |                    |                     |        |            |          |
| 20  | Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх  | x      |          |         | x   |                  | x                  |                     |        | x          |          |
| 21  | Түүх, соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх  |        |          |         |     |                  |                    |                     |        |            |          |
| 22  | Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх  |        |          |         |     |                  |                    |                     |        |            |          |
| 5. Бусад нөлөөлөл   |   |        |          |         |     |                  |                    |                     |        |            |          |
| 23  | Үйлчилгээний үйл ажиллагааг хангахтай холбоотойгоор байгаль орчин элэгдэл доройтолд орох (барилга байгууламж, асфальтан зам, эрчим хүч, дулаан, цэвэр, бохир усны нэгдсэн системд холбогдох шугам татах, суваг шуудуу ухах зэрэг) | x      |          |         | x   |                  | x                  |                     |        | x          |          |
| 24  | Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн, химийн бодис асгаран хөрсөнд нэвчиж, хөрс ба грунтны ус бохирдуулах   | x      |          |         | x   |                  | x                  |                     |        |            | x        |
| 25  | Хатуу хог хаягдлын цэгийн байрлал, ил задгай байлгах болон шингэн хаягдлын шугам хоолой, түүний дамжуулах хоолойд гэмтэл гарах тохиромжгүй байдал (үнэр) үүсэх  | x      |          | x       |     |                  | x                  |                     |        |            | x        |
| 32  | Барилгын ажлын хатуу, шингэн хаягдлаар байгаль орчин бохирдох   | x      |          |         | x   |                  | x                  |                     |        |            | x        |
| 33  | Хүчтэй салхи, түймэр, газар хөдлөл, аянга   |        | x        |         | x   |                  | x                  |                     |        |            | x        |
|   | Дүн   | 25     | 6        | 0       | 3   | 21               | 4                  | 20                  | 3      | 12         | 9        |

Дээрх хүснэгтээс харахад тус төслийн үйл ажиллагааны явцаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл өөр хоорондоо харилцан уялдаа холбоотой нэг нь нөгөөдөө шууд буюу дам байдлаар нөлөөлөх нь харагдаж байна.

**Төслийн байршил, шийдэлтэй холбоотой болзошгүй нөлөөлөл**

Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших “Баруун Баруун урт”-ын алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн байршил, техник-технологийн шийдэл, төлөвлөлт болон төслийн хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдсон болзошгүй нөлөөллийг тодруулахын тулд “магадлан жагсаах” (checklists) аргыг хэрэглэн үр дүнг нь хүснэгтэнд илэрхийлэв.

**Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлах жагсаалт**

Хүснэгт №16

| Байгаль орчны асуудлууд   | Гол нөлөөлөл байхгүй | Гол үр дагавар |      |           |
|---|----------------------|----------------|------|-----------|
|   |                      | Бага /муу/     | Дунд | Их /сайн/ |
| <b>1. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал</b>  |                      |                |      |           |
| Голын голдрилыг өөрчлөх, эрэг эвдрэн үерийн ус тавих нөхцөл бүрдэх  | x                    |                |      |           |
| Төслийн байршилтай холбогдож хүн амын нүүдэл бий болох, хүн амыг зөөж байршуулах шаардлага гарах  | x                    |                |      |           |
| Ой модыг огтлох явдал гарах   | x                    |                |      |           |
| Түүх, соёлын дурсгалт газрыг эвдэхэд хүрэх  | x                    |                |      |           |
| Усан хангамж, ус хэрэглээний асуудлаар өөр байгууллагын үйл ажиллагаатай зөрчилдөх  | x                    |                |      |           |
| Бүс нутгийн үерийн болон булаг, шанд хатах, ширгэх аюул гарах эсэх  | x                    |                |      |           |
| <b>2. Үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төсөөллийг багтаасан төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал</b>   |                      |                |      |           |
| Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, эрдэс түүхий эдийг олзворлох, боловсруулах болон бохирдлын хяналтын сонгосон төхөөрөмж нь хир зэрэг зохимжтой          |                      |                | x    |           |
| Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс сэргийлэн хамгаалах болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал хэрхэн төлөвлөгдсөн   |                      |                |      | x         |
| Элс олборлох үед болон уурхайгаас гарах гүний болон гадаргын усыг хамгаалах, өвөрмөц хорт металл, нэгдлээс хамгаалах асуудал хир нийцтэй тусгагдсан, үр ашигтай ажиллах явдал хир зэрэг зохимжтой |                      |                | x    |           |
| Гидравлик даралттай усны боолтоор гарах булингартай усыг тунгаах, урсгал усны чанарыг хамгаалах, хянах асуудал  |                      |                | x    |           |
| Уурхайн үйл ажиллагааны үед гарах шуугианыг тогтоосон хэмжээнээс багасгах тухай төсөлд тусгагдсан эсэх  |                      | x              |      |           |
| Тусгай анхаарал тавих шаардлагатай шороо, тоос, утаа гардаг эсэх  |                      |                | x    |           |
| Эрдсийг боловсруулах технологийн үйл ажиллагааны үед ус, агаар, хөрс бохирдох, хатуу хог хаягдал гарах, их дуу чимээ гарах  |                      |                | x    |           |
| <b>3. Барилга, байгууламжийн хийц, барихтай холбогдож гарах байгаль орчны асуудал</b>   |                      |                |      |           |
| Барилга байгууламжийг барих үед усны булингар бий болох   | x                    |                |      |           |
| Барилга, байгууламжийг барих үеийн болон барьсны дараахь хөрсний эвдрэл, элэгдэл  |                      |                | x    |           |
| Ажиллагсдын төрөл бүрийн аваарь, осолд өртөх байдал, хортой нөхцөл, халдвартай өвчин гарах нөхцөл   |                      | x              |      |           |
| <b>4. Төслийн үйл ажиллагааны үеийн байгаль орчны асуудал</b>   |                      |                |      |           |
| Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаархи төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх   |                      |                |      | x         |
| Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх   |                      |                | x    |           |

|   |           |          |          |          |
|---|-----------|----------|----------|----------|
| Хөрсний элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд хир тусгагдсан /хөрсжүүлэх ургамал тарих, нүхийг буцааж тэгшлэх зэрэг/  |           |          | x        |          |
| Хурдасыг тонох, авч ашиглах зэргээс шалтгаалж ус нэвчих, гүний ус бохирдох, улмаар хөрсний усны горимд эсрэгээр нөлөөлөх  |           | x        |          |          |
| Газар ашиглалтанд хохирол учруулах /уурхайн үйл ажиллагаа явуулах үед газар тэгшлэх, буцааж булаах ажлыг хамгийн бага байлгах нь бусад зорилгод ашигтай байж болох, хөрш зэргэлдээх газар ашиглагчдад хохирол учруулахгүй байх зэрэг асуудал төсөлд тусгагдсан эсэх |           |          |          | x        |
| Шуурхай хяналтын асуудал /төсөлд шуурхай хяналтын хугацаа, мөнгө зардал тусгагдсан эсэх/  |           |          | x        |          |
| <b>5. Боломжтой арга хэмжээг нэмж авах асуудал /газар доороос ухаж гаргасан овоолго элсийг ялгах болон бүхэлд нь цементийн үйлдвэрт ашиглах г.м/</b>  |           | x        |          |          |
| <b>6. Төслийн бусад асуудал /төслийн инженерийн болон санхүү, эдийн засгийн боломжийн талаархи асуудал/</b>   |           |          |          | x        |
| <b>7. Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд /бодлогын чанартай асуудлууд/</b>   |           |          |          |          |
| Төслийг хэрэгжүүлэх явцад байгалийн бусад олдошгүй нөөц баялгийг зөвтгөх аргагүйгээр гарздах /жишээ нь: алт олборлох үед хүлрийн давхарга тааралдах г.м./   | x         |          |          |          |
| Төслийг хэрэгжүүлэхдээ ядмаг нөөцийг удаан хугацааны туршид ашиглах эдийн засгийн зорилтыг хэт түргэн хугацаанд үндэслэлгүйгээр ашиглах   | x         |          |          |          |
| Төслийн үр дүн нь биологийн төрөл зүйлд осолтой, аюулд хүргэх /генфондод нөлөөлөх, ховор, нэн ховордсон амьтан ургамал устгах г.м./   | x         |          |          |          |
| <b>Дүн</b>  | <b>10</b> | <b>4</b> | <b>9</b> | <b>4</b> |

#### 4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тухайн жилийн зорилт

2024 онд уурхайн эдэлбэр газарт 3.33539 га газарт олборлолт хийх 4.0 га-д техникийн, мөн га-д биологийн өссөн дүнгээр бүгд 8.0 га талбайд байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлыг тус тус хийж гүйцэтгэнэ.

“Баруун Баруун-Урт алтны шороон орд”-ын ил уурхайд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголыг холбогдох хууль, журмын дагуу 2021 онд хийлгэсэн.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд “Хунан” ХХК-ийн Баруун баруун уртын (MV-08097) алтны шороон ордыг ашиглах төслийн байгаль орчны менежментийн талаар анхаарах шаардлагатай асуудлууд болон зорилтууд нь дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

- Уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орох талбайд жил бүрийн уулын ажлын төлөвлөлт болон тухайн жилийн байгаль орчны менежмент төлөвлөгөөний хүрээнд холбогдох аргачлал, стандартын дагуу техникийн ба биологийн нөхөн сэргээлтийг хийж орон нутагт хүлээлгэн өгөх,
- Уурхайн хаалт-нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулах, орон нутгийн иргэдээр хэлэлцүүлж, төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах
- Уурхайн талбайд байгаль орчны үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах албан тушаалтныг томилж, байгаль орчны чиглэлээр дотоодын хяналт ба ажилчдад зориулсан сургалт сурталчилгааг тогтмол явуулж хэвших,
- Байгаль орчныг хамгаалах ба байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу жил бүрийн байгаль орчны менежмент төлөвлөгөөг боловсруулж, гүйцэтгэлийг өндөр түвшинд байлгах, мөн байгаль орчны хугацаат аудит, газрын төлөв байдал, чанарын баталгааг хийлгэх,
- Уурхайн үйл ажиллагаа ба барилга байгууламж, ажилчдын байрнаас үүсэх хог хаягдалтай холбоотойгоор хог хаягдлын менежментийн зохих зарчмыг хэрэгжүүлж, үүсэх хог хаягдлыг багасгах, түүнийг дахин ашиглах, дахин боловсруулах ажил зохион байгуулах
- Орчны хяналт шинжилгээг хуваарийн дагуу явуулж уурхайн үйл ажиллагаанаас үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөлд хяналт тавих,

- Үйл ажиллагааны явцад үүсэх орчны тоосжилтыг хамгийн бага байлгахад анхаарч ажиллах, тайлангийн холбогдох зөвлөмжийг хэрэгжүүлэх зэрэг болно.

**5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

Баруун баруун уртын алтны шороон ордыг олборлох уурхайн байгаль хамгаалах төлөвлөгөөг, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10 сарын 31-ны өдрийн А-618 дугаар тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангаас ишлэн боловсруулав.

2024 онд уурхайн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу агаарын чанар, гадаргын ба газрын доорхи ус, амьтны аймаг, ургамлан нөмрөг, бохирдлыг багасгах, хөрсөн бүрхэвч, газрын гадарга, хэвлий зэрэгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах багасгах зэрэг чиглэлүүдээр бүлэглэн Хүснэгт №18-д үзүүлэв.

үснэгт № 18

| №                  | Гол ба болзошгүй сөрөг нөлөө  | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ  | Арга хэмжээний цар, хэмжээ                     | Нэгжийн өртөг, мян.төг.      | Нийт зардал, мян.төг. | Хугацаа ба давтамж        | Баримтлах стандарт, аргачлал   |
|--------------------|---|--|--|------------------------------|-----------------------|---------------------------|--|
| <b>Агаар орчин</b> |   |  |  |                              |                       |                           |  |
| 1                  | Уурхайн олборлолт болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд:<br><br>Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолт, бутлалт овоолго зэрэг газар шорооны ажил      | Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдэд Монгол Улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын стандартууд (MNS 5013:2003 бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид, MNS 5014:2003 дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид) болон олон улсын холбогдох стандартуудын шаардлагын дагуу хяналт хийж түүнд нийцүүлнэ | Төсөлд ашиглагдах бүх техник тоног төхөөрөмжид | Үйл ажилалгааны зардалд орно |                       | Олборлолт эхлэхийн өмнө   | -Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, -MNS4585:2007 (Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага) -MNS3383:1982 (Агаар мандал, Бохирдлын эх үүсвэр, нөхцөл байдал ба тодорхойлолт) -MNS5885:2008 (Агаар бохирдуулагч бодисуудын хүлээн зөвшөөрөгдсөн концентрац, Техникийн ерөнхий шаардлага) -MNS4225:2011 (Агаарын чанар, Ерөнхий танилцуулга) |
|                    | Ажилчдын суурин болон уурхайн олборлолтын үеийн газар шорооны ажил<br><br>Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хөдөлгөөн, тээвэрлэлтэнд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох | Уурхайн машин механизмуудын янданд шүүлтүүр тавина /TWCAT002, TWCAT006 1 маркийн шүүлтүүр/   | Төсөлд ашиглагдах техник тоног төхөөрөмжид     | Үйл ажилалгааны зардалд орно |                       | Олборлолт од гарахын өмнө |  |

Баруун Баруун урт уурхайн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөө  | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ  | Арга хэмжээний цар, хэмжээ               | Нэгжийн өртөг, мян.төг.                      | Нийт зардал, мян.төг. | Хугацаа ба давтамж                     | Баримтлах стандарт, аргачлал   |
|---|---|--|--|--|-----------------------|--|--|
|   | Уурхайлалтаас ялгарах тосжилт, ууршилт бүхий хэсгүүд салхиар дамжин хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй. | Олборлолтын ажлын үед газар шорооны ажлыг аль болохоор бага хэмжээтэй хязгаартай хийнэ   | Уулын ажлын үед                          |  |                       | Төслийн бүх үе шатанд                  | -MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд)<br>-Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003<br>-Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003<br>MNS5010-2001, “ХААЭА. Ажлын байран дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага” |
|   |   | Хучилтгүй зам дээр тээвэр хийх машины хурдыг хязгаарлана   | Уурхайн зам болон орон нутгийн зам       |  |                       | Төслийн бүх үе шатанд                  |  |
|   |   | Машинаас гарах тоос шороог багасгах үүднээс хучилтгүй замын гадаргыг шаардлагатай хэсгүүдэд засна (олборлолтын ажлаас өмнө),               | Уурхайн зам                              | Үйл ажиллагааны зардалд тусгана              |                       | Төслийн бүх үе шатанд                  |  |
|   |   | Тоосжилтыг дарах зорилгоор авто зам, уурхайн карьерийн мөргөцөг, шимт хөрсний овоолгын тоосжилтоос хамгаалах усалгаанд ус ашигласны төлбөр | Уурхайн зам, карьерийн мөргөцөг, овоолго | Үйл ажиллагааны усны төлбөрийн зардалд орсон |                       | Төсөл хэрэгжих хугацаанд               |  |
| 2 | Уурхайлалт, олборлолт, техник тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны улмаас дуу чимээ ихээр үүсэж ажилчид                           | Замыг засварлан сайжруулж тэмдэгжүүлнэ   | Уурхайн болон орон нутгийн замд          | 400.0  | 400                   | Төсөл хэрэгжих хугацаанд               | -MNS ISO 226:2003 дуу чимээ-хэвийн норм-түвшний хэмжээ   |
|   |   | Олборлолтын ажлыг өдрийн цагаар гүйцэтгэнэ.  | Уурхай дотор                             |  |                       | Төлөвлөлт, олборлолтын ажлын үе шатанд |  |

Баруун Баруун урт уурхайн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

| №                | Гол ба болзошгүй сөрөг нөлөө  | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ  | Арга хэмжээний цар, хэмжээ      | Нэгжийн өртөг, мян.төг.                    | Нийт зардал, мян.төг. | Хугацаа ба давтамж  | Баримтлах стандарт, аргачлал   |
|------------------|---|--|---------------------------------|--|-----------------------|---|--|
|                  | болон нутгийн иргэд дуу чимээний бохирдолд орх  | Дуу шуугианы хэмжилт (1 цэгт дууны түвшин хэмжигч NL-04 багажаар) хийж, дуу, шуугиан бүхий машин механизмийн ашиглалтыг оновчтой төлөвлөх, үр ашиггүй ашиглалтыг багасгана. Уг багажийг хэрэв БОШТЛ, “ОС МТ” ХХК зэргээс түрээслэвэл түрээсийн зардал нэг удаа 30000 төг   | Лицензийн талбайд               | Орчны хяналт шинжилгээний зардалд орсон    | -                     | Жилд нэг удаа дууны түвшин хэмжигч NL-04 багажаар хэмжилтийг хийнэ. |  |
| 3                | Алтны хүдрийг боловсруулах технологийн үйл ажиллагааны явцад синилийн, давсны ба хүхрийн хүчил уурших, агаарт ялгарах   | Агаарын чанарт тавих хяналтын хүрээнд үйлдвэрийн агаар дахь хорт бодис (HCN, HCl, H <sub>2</sub> SO <sub>4</sub> , SO <sub>3</sub> , SO <sub>2</sub> )-ын агууламжийг тодорхойлж байх  | Баяжуулах үйлдвэрт              | Орчны хяналт шинжилгээний зардалд тусгасан |                       | Төслийн үйл ажиллагааны туршид                                      |  |
| 4                | Төслийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй химийн ууршигтай, дэгдэмхий бодисууд агаарт уурших, исэлдэх урвалд орох, салхиар тарах зэргээр агаарын чанар, найрлагыг өөрчлөх, Хаягдлыг шатаах аргаар устгах үед хортой хий ялгаран агаарын чанарт сөргөөр нөлөөлөх<br>Болзошгүй галын аюул, осол аваарын үед гарах хорт хийн дэгдэлт агаарын чанарт нөлөөлөх<br>Химийн бүтээгдэхүүн, түлш шатахуун асгарч алдагдсанаас орчны агаар бохирдох | Бүх төрлийн химийн бодис, ялангуяа шатамхай шингэнийг халаалтын хэрэгсэл, системээс хол, нарны шууд гэрэл тусахааргүй, үер усанд автахааргүй нөхцөлд хадгалах<br>Химийн бүтээгдэхүүн, бодис хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, Агаарын чанарыг хянах, шинжлэх байнгын ажиллагаатай багаж, тоног төхөөрөмж суурилуулан түүний мэдээллийг ашиглах | Уурхай болон үйлдвэрийн талбайд | Үйл ажиллагааны зардалд тусгах             |                       | Төслийн үйл ажиллагааны туршид                                      | Агаарын тухай болон агаарын бохирдлын хууль /2012.05.17/ MNS 0017-2-3-16:1998 (Суурьшилын хэсгүүдэд) MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага Галын аюулгүй байдлын тухай хууль/2012.05.17/ ”Гамшгаас хамгаалах тухай” хууль |
| Усны нөөц, чанар |   |  |                                 |  |                       |   |  |

**Баруун Баруун урт уурхайн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

| №                             | Гол ба болзошгүй сөрөг нөлөө   | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ  | Арга хэмжээний цар, хэмжээ                            | Нэгжийн өртөг, мян.төг.                                | Нийт зардал, мян.төг. | Хугацаа ба давтамж                     | Баримтлах стандарт, аргачлал  |
|-------------------------------|--|--|---|--|-----------------------|--|---|
| 1                             | Газрын доорх усыг авч ашигласнаар газрын доорх урсацын горим алдагдах, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамалжилтад сөргөөр нөлөөлж болзошгүй. | ШТМ-ын агуулахын орчмыг хайрган хучилттай болгоно  | ШТМ-ын агуулах болон түүний орчим                     | -  | -                     | Төлөвлөлт, олборлолтын ажлын үе шатанд | -Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль -ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт-Ус ашигласны төлбөрийн хувь хэмжээ  |
|                               |  | Уурхайн олборлолтын ажлын явцад орчны тоосжилтыг бууруулахад газар доорх усны нөөцийг аль болох ашиглахаас зайлсхийж, цэвэршүүлсэн ахуйн хаягдал усыг эргүүлж ашиглана | Лицензийн талбайд                                     | -  | -                     | Олборлолтын ажлын үе шатанд            |   |
|                               |  | Ундны усны гүний худагт эрүүл ахуйн бүс тогтоож хашаалж хамгаалах  | Гүний худагт  | -  | -                     |  |   |
| 2                             | Шатах тослох материалын алдагдал, асгаралт болон химийн бодисын агууламж бүхий үерийн урсацаар гадаргын ус бохирдох  | Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт үерийн ус зайлуулах системийг байгуулах, химийн бодис болон шатах, тослох материал алдагдахаас сэргийлэх                                 | Төслийн нийт талбайд                                  | Үйл ажиллагааны зардалд тусгаж ажиллах ОХШХ-т тусгасан |                       | Үйл ажиллагааны туршид                 | “Усны тухай” хууль/2012.05.17/<br>“Рашаан, ус ашигласны төлбөрийн тухай” хууль. Усны нөөцийг бохирдлоос хамгаалах дүрэм. БО болон ЭМ-ийн сайд нарын хамтарсан тушаал 167/335/A171 MNS 4586:1998<br>Усан орчны чанарын үзүүлэлт. MNS 3342:1982<br>Газрын доорх усыг бохирдлоос хамгаалах |
| 3                             | Газрын доорх усыг авч ашигласнаар газрын доорх урсацын горим алдагдах, нөөц хомсдох  | Төслийн ус хэрэглээнд ашиглах 5 гүний худгийн 2 гүний худгаас усны түвшин бууралтыг хэмжиж паспорт хөтлөх  | Төслийн таблайн технологит ашиглагдахгүй гүний худагт | 500  | Сард 1 удаа           |  |   |
| <b>Хөрс, ургамлан бүрхэвч</b> |  |  |   |  |                       |  |   |
| 1                             | Уурхайн ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт  | Уурхайн орчны авто замд тэмдэгжүүлэх ажил хийх, олон салаа зам гаргахаас сэргийлнэ   | Төсөл хэрэгжих талбай болон түүний орчим              | Үйл ажиллагааны зардал тусгана.                        |                       | Төслийн эхэнд                          | -Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг  |



Баруун Баруун урт уурхайн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөө  | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ  | Арга хэмжээний цар, хэмжээ                                 | Нэгжийн өртөг, мян.төг.                          | Нийт зардал, мян.төг. | Хугацаа ба давтамж  | Баримтлах стандарт, аргачлал   |
|---|---|--|--|--|-----------------------|---|--|
|   | орох, хог хаягдал тоосжилтоос бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх. ШТМ, барилгын материалын хог хаягдал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах  | Ил уурхай болон газар эвдэх бусад үйл ажиллагаануудыг эхлүүлэхээс өмнө өнгөн хөрсийг хуулан авах. Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон түүний явцад хуулан авсан өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгална   | Төсөл хэрэгжих талбайд                                     |  |                       | Төлөвлөлт, олборлолтын ажлын үе шатанд  | тодорхойлох арга, -MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
|   |   | Хог хаягдлыг тээвэрлэж зайлуулна   | Мэргэжлийн байгууллагатай гэрээ хийн ажиллах               | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан. | Тухай бүрд            |   |  |
|   |   | ШТМ-ын хадгалалтанд хяналт тавина  | ШТМ-ын агуулахад   | Үйл ажиллагааны зардал тусгана.                  | Тухай бүрд            |   |  |
|   |   | Олборлолтын ажил, түүний овоолго, тээвэрлэлт нь тус талбайн хөрсний эвдрэлийг аль болох бага байлгахад чиглэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тухайн тогтоогдсон ажлын зурваст байлгах арга хэмжээ авах  | Уулын ажил   |  | -                     | Төсөл хэрэгжих явцад  |  |
|   | Химийн бодис, бүтээгдэхүүнийг хадгалах агуулахын барилгын инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдолоос үүдэн хөрсөнд химийн бодис алдагдах, Тээвэрлэх түгээх, хүлээн авах үйл ажиллагаа зохих журмын дагуу явагдаагүйгээс химийн бодисыг хөрсөнд алдаж, бохирдол үүсгэх, Хөрсөнд химийн | Химийн хорт болон аюултай бодисыг зориулалтын агуулахад, хор аюулын лавлах мэдээлэлд заасан нөхцөлд хадгалах, химийн бодисын хадгалалт, ашиглалт, зарцуулалтанд тогтмол хяналт тавих, Химийн бодис агуулсан шингэн хаягдлыг хөрсөнд үл нэвчүүлэх, хальж асгарахаас сэргийлэх, Химийн бодис асгарч гоожих эрсдэлтэй ажлын байруудад шингээх бодис, материалыг хангалттай хэмжээгээр байршуулах, | Химийн бодисын агуулах, баяжуулах үйлдвэр, уурхайн талбайд | Үйл ажиллагааны зардалд тусгах                   | Төсөл хэрэгжих явцад  | Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам. БОАЖ-ын сайд, ЭМ-ийн сайд, ОБЕГ-ын даргын 28/40/29 дүгээр хамтарсан тушаал, 2009 Хог хаягдлын тухай хууль/2012.05.17/ Зүйл 12, Зүйл 13, Зүйл 14, Зүйл 16. |  |

| №            | Гол ба болзошгүй сөрөг нөлөө  | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ  | Арга хэмжээний цар, хэмжээ                    | Нэгжийн өртөг, мян.төг. | Нийт зардал, мян.төг. | Хугацаа ба давтамж                   | Баримтлах стандарт, аргачлал |
|--------------|---|--|---|-------------------------|-----------------------|--------------------------------------|------------------------------|
|              | бодис алдагдсанаас ургамал, гадаргын болон газар доорх ус, ан амьтанд дам нөлөөлөл учруулах, Химийн бодисын сав баглаа боодлыг зориулалтын бус аргаар устгалд оруулах, ил хаяж хөрс бохирдуулах | Химийн бодисын үлдэгдэл, хаягдлыг устгах ажлыг зохих хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх, тогтмол хяналт тавих.<br>Хөрс бохирдуулагч хүнд хортой металлуудыг тогтмол хугацаанд, тодорхой цэгүүдээс авсан дээжинд шинжлэх |   |                         |                       |                                      |                              |
| Амьтны аймаг |   |  |   |                         |                       |                                      |                              |
| 6            | Ухсан нүх, карьерт амьтад орж үрэгдэх, дуу чимээний нөлөөллөөс үргэж дайжих   | Уурхайн бүсэд хамгаалалтын хашаа барих, шувууны үүр барьж өгөх   | Лицензийн талбайн ойр орчим болон орон нутагт | -                       |                       | Үйл ажиллагааны явцад байнга ажиглах | Амьтны тухай хууль           |
| Нийт зардал  |   |  |   | <b>900</b>              | 900                   |                                      |                              |

### 6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

2024 онд уурхайн олборлолт 3.33539 га, угаах төхөөрөмжийн орчинд 1.5 га, авто зам 1.5 га, хотхон ба засварын газар түүний орчны талбай 0.35 га, шимт хөрсний овоолго 0.5 га, эргэлтийн усны нуурууд 1.44 га бүгд 8.54 га газарт үйл ажиллагаа явуулна.

2024 онд өөрийн уурхайн 4.0 га-д техникийн, 4.0 га-д биологийн, өссөн дүнгээр бүгд 8.0 га талбайд байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлыг хийнэ.

#### А. Нөхөн сэргээлтийн ажилд баримтлах стандартууд

Монгол улсын зохих хууль, дүрэм стандартууд, тушаал шийдвэрүүдийн дагуу байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн ажил хийгдэнэ. Зохих хууль дүрэм, стандартуудыг хэрэгжүүлэхдээ: “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт MNS5914:2008” стандартыг голчлон баримтална. “Уул, уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаар эвдэрсэн газрын ангилал” MNS5915:2008, “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт” MNS 5916:2008, “Уул, уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаар эвдэрсэн газрын ангилал ”MNS5917:2008 “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага” MNS 5918:2008 гэх мэт стандартуудыг мөрдөж ажиллана.

#### Б. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал:

Ордыг ил уурхайгаар ашиглах явцад эвдэрсэн газрыг MNS5915-2008-стандартын дагуу :

##### 1. Ил уурхайн ухаш:

Эвдэрсэн газрын гадаргуугийн хэвшилтийн тодорхойлолтоор - хонхорхой.

Гадаргууг хэвшүүлэх хүчин зүйл - хэвтээ уналтай, бага зузаантай (3.0 м хүртэл) биетийг 1 доголоор олборлох, хөрс хуулалт багатай ашиглалт.

Гадаргуугийн зонхилох элемент – ёроолын талбай, догол (уступ)

2. Гадаргуугийн үүслийн тодорхойлолт:

Жинхэнэ гадаргуутай харьцуулах гүн буюу өндөр - тах 3.0м  
Доголын налуугийн өнцөг - 60°

3. Уурхайд хийх овоолго:

Уурхайд шимт хөрсний гадаад (түр), хөрсний дотоод овоолго хийнэ.

4. Ил уурхайгаар ашиглах явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээж аж ахуйн эргэлтэнд оруулах чиглэл

“Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал. MNS 5916:2008” стандартын дагуу ил ба далд уурхайн аргаар ашиглах явцад эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийж, аж ахуйн эргэлтэд оруулах чиглэлийн дагуу “Баруун урт” алтны ордыг ил аргаар ашиглах явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээж цаашид бэлчээрийн зориулалтаар ашиглана.

5. Шимт хөрсний бүтэц, шинж чанарт тавих шаардлага, хадгалалт

«Баруун Баруун урт» алтны ордын үржил шимт хөрс нь «шимт хөрсний үндсэн үзүүлэлт»-ээр хээрийн бүсийн хөндийн гарал үүсэлтэй, ургамлын үндэстэй бага зэргийн шавранцартай цайвар бор хар хүрэн, хүрэн өнгийн, ялзмагийн агуулга нь 2.33-3.99 %-тай, хөрсний орчин нь рН=7.11 гэсэн ангилалд багтана. Уурхайн олборлолтын үед хуулах шимт хөрс нь ордын ашигт малтмалыг хучиж буй дунджаар 0.3 м зузаантай давхрага юм. Шимт хөрсийг олон жилээр хадгалахгүй тухайн жилд нь нөхөн сэргээлтэнд түр овоолгод хадгална

6. Нөхөн сэргээлтэнд ашиглах техник тоног төхөөрөмжүүд

Нөхөн сэргээлтийн ажлыг элс-хайрганы орд газрыг ашиглаж байгаа уурхай өөрийн хүч, хөрөнгөөр гүйцэтгэнэ. Уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг ашиглалтын ажилтай зэрэгцүүлэн явуулна. жиллах техник: Экскаватор Hyundai300LC-7, Шууд утгуурт дугуйт ачигч ZL-50, Автосамосвал FAW 25tn. Нөхөн сэргээлтийн зардлын дүнг хүснэгт № 22-г үзүүлэв.

Хүснэгт №22

| д/д  | Зардлын утга  | Хэмжих нэгж        | Ажлын хэмжээ | Ашиглагдах техник, тайлбар                            | Нэгж ажлын зардал төг | Нийт зардал мян.төг. |
|--|---|--------------------|--------------|---|-----------------------|----------------------|
| <b>Бэлтгэл ажлын зардал</b>                    |   |                    |              |   |                       |                      |
| 1  | Нөхөн сэргээлтийн ажлын Хөрөнгө оруулалтын зардал     | сая.төг            |              | Шаардлагатай Хөрөнгө худалдан авахад зарцуулах зардал |                       | -                    |
| 2  | Байгаль орчны суурь төлөв байдлын шинжилгээний зардал | сая.төг            |              | Тооцоогоор шаардлагатай судалгаа хийх зардал          |                       | -                    |
| 3  | Нөхөн сэргээлтийн ажлын төсөл боловсруулах зардал     | сая.төг            |              | Нөхөн сэргээлтийн зардлын төсөвт өртгийн 3-5%         |                       | 500.0                |
| А. Нөхөн сэргээлтийн бэлтгэл ажлын зардлын дүн |   |                    |              |   | <b>500.0</b>          |                      |
| <b>Техникийн нөхөн сэргээлтийн ажил</b>        |   |                    |              |   |                       |                      |
| 4  | Шимт хөрсний үе давхаргыг хуулах, ачих, хадгалах      | мян.м <sup>3</sup> |              | -   | а, а <sub>э</sub>     | -                    |
| 5  | Хөрс тээвэрлэх  | мян.м <sup>3</sup> |              | Утгуурт ачигч, экскаватор                             | а <sub>т</sub>        | -                    |
| 6  | Уурхайн малталтыг дүүргэж, тэгшлэх                    | мян.м <sup>3</sup> | 3.12         | Экскаватор, Утгуурт ачигч                             | а <sub>тэгш</sub>     | 2651.3               |
| 7  | Овоолгын талбайг хэлбэржүүлэн тэгшлэх, нягтаршуулах   | мян.м <sup>3</sup> |              | Экскаватор, Утгуурт ачигч                             | а <sub>нягт</sub>     |                      |
| 8  | Шимт хөрсөөр талбайг хучих                            | мян.м <sup>3</sup> |              | экскаватор  | С <sub>нийт</sub>     |                      |
| 9  | Тэгшилсэн талбай дээр дэвссэн хөрсний үеийг тэгшлэх   | мян.м <sup>3</sup> | 3.51         | -   | а <sub>тэгш</sub>     | 2956                 |
| 10   | Уурхайн ханыг хэвгийжүүлэх, дэвсгэжүүлэх              | мян.м <sup>3</sup> | 0.132        | Экскаватор  | З <sub>тэгш.</sub>    | 114.3                |

**Баруун Баруун урт уурхайн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

|  |  |                    |                  |                |                   |       |
|--|--|--------------------|------------------|----------------|-------------------|-------|
| 11   | Туслах байгууламж байгуулахад үүссэн овоолгыг тэгшлэх          |                    |                  | -              | а <sub>тэгш</sub> | -     |
| 12   | Ургамалжуулахад бэлтгэн хөрсийг нягтаршуулах                   | м <sup>2</sup>     |                  | -              |                   | -     |
| 13   | Хөрс боловсруулах, сайжруулах                                  | мян.м <sup>3</sup> |                  |                | а <sub>х</sub>    | -     |
| 14   | Шимт хөрсийг хадгалах, хамгаалах                               |                    |                  |                |                   | -     |
| В.Техникийн нөхөн сэргээлтийн ажлын дүн              |  | мян.төг            |                  | <b>5722</b>    |                   |       |
| Биологийн нөхөн сэргээлтийн ажлын зардал             |  |                    |                  |                |                   |       |
| 15   | Судалгаа туршилт   |                    |                  |                | З <sub>с</sub>    | 200.0 |
| 16   | Хөрс бэлтгэх боловсруулах                                      |                    |                  |                | З <sub>хөрс</sub> | 200.0 |
| 17   | Ургамалжуулах  |                    |                  |                | З <sub>у</sub>    | 7424  |
| 18   | Усалгаа, арчилгаа, хамгаалалт хийх                             |                    |                  |                | З <sub>хам.</sub> | 500.0 |
| С.Биологийн нөхөн сэргээлтийн ажлын дүн              |  | мян.төг            |                  | <b>8324</b>    |                   |       |
| Хаалтын дараах хяналт-шинжилгээний ажлын зардал      |  |                    |                  |                |                   |       |
| 19.  | Нөхөн сэргээгдэж байгаа явцын хяналт-шинжилгээний ажлын зардал | мян.төг            | З <sub>мон</sub> |                |                   |       |
| 20.  | Орон нутагт хяналт-шинжилгээ хийх үлдээх хөрөнгө               | мян.төг            | З <sub>хян</sub> |                |                   |       |
| Д. Хаалтын дараахь хяналт- шинжилгээний ажлын зардал |  | мян.төг            |                  | <b>562</b>     |                   |       |
| Нөхөн сэргээлтийн ажлын нийт зардлын дүн             |  | мян.төг            | З <sub>нс</sub>  | <b>15108.0</b> |                   |       |
| 21   | Жил тутам хуримтлуулах хөрөнгө                                 | мян.төг            |                  | -              |                   |       |

**7. Байгаль Орчны нөхөн сэргээлтийн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

Энэ ажлын хүрээнд Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2024 оны 02-р сарын 07-ны өдрийн № 07/41 санал... “2024 оны Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд өгөх санал” -ыг үндэслэн Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг Уртын гол (Баруун баруун урт) нэртэй газарт 8.3 гектар талбайд нөхөн сэргээлт хийхээр төлөвлөв.

Энд гарах зардлын урьдчилсан төлөвлөлтийн тооцоо: “§6. Нөхөн сэргээлтэнд ашиглах техник тоног төхөөрөмжүүд” Нөхөн сэргээлтийн зардлын дүнг хүснэгт № 22-оос ишлэн тооцов.

4 га талбайд (5722 мян.төг – 500 мян.төг = 5222 мян.төг) эндээс 5222 мян.төг / 4 га = 1305.5 мян.төг./га.

Зардал: 1305.5 мян.төг./га \* 8.3 га = 10835.65 мян.төг. буюу 10.8 сая төгрөг байхаар тооцов.


Энэ зардал уурхайн үйл ажилгааны зардлаас гарна.

Байгаль Орчны нөхөн сэргээлтийн дүйцүүлэн хамгаалах талбайн байршил, булангийн эргэлтийн цэгийн солбицлыг дараах зураглалд үзүүлэв.

Баруун Баруун урт уурхайн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Байршил: Төв аймгийн Сэргэлэн сум, Баруун баруун урт

"Хунан" ХХК



Солбицлын тогтолцоо: UTM, WGS-84

Масштаб 1:4000  
Нэг сантиметрт 40 метр багтана.

Зураглалыг хийсэн: Уул уурхайн инженер С.Ганбат

### 8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбайд айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэх шилжүүлэх ажил хийгдэхгүй болно. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Хүснэгт №25

| №    | Нөлөөлөлд өртөх иргэд  | Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ                                  | Арга хэмжээний цар, хэмжээ  | Нэгжийн өртөг  | Нийт зардал (сая.төг) | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал                   |
|------|--|--|---|--|-----------------------|--------------------------------|--|
| 1    | Төсөл хэрэгжих АМТЗ-ийн талбайн ойр, орчим болон нөлөөллийн бүсэд нутаглаж амьдардаг иргэд | Шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох | Уурхайн нөлөөлөлд өртсөн, нүүлгэн шилжүүлэх айл өрхийн хэмжээгээр | Харилцан тохиролцох замаар<br>Үйл ажиллагааны зардлаас |                       | 2024                           | “Ашигт малтмалын тухай” хуулийн 41 дүгээр зүйл |
| Нийт |  |  |   |  | -                     |                                |  |

### 9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Олборлолтын явцад археологи, палеонтологи, түүх, соёлын дурсгалт зүйлс илэрвэл уулын ажлыг зогсоон сумын ЗДТГ, мэргэжлийн зохих байгууллагад яаралтай мэдэгдэж, авран хамгаалах, цаашлаад нүүлгэн шилжүүлэх ажлыг гүйцэтгэнэ.

Мөн төсөл хэрэгжүүлэгч нь тухайн бүс нутгийн соёлын биет бус өвийг хамгаалах, хадгалах чиглэлээр компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд тухайн нөхцөлд тодорхой ажил төлөвлөн хэрэгжүүлж болно. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөг дараах хүснэгт №25-д үзүүлэв.

Хүснэгт №25

| № | Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд          | Хамгаалах арга хэмжээ  | Арга хэмжээний цар, хэмжээ                                       | Нэгжийн өртөг            | Нийт зардал (сая.төг) | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал       |
|---|--|--|--|--------------------------|-----------------------|--------------------------------|------------------------------------|
| 1 | Орд орчим байж болзошгүй түүх соёлын өвүүд | Шаардлагатай тохиолдолд авран хамгаалах арга хэмжээ зохион байгуулах | Судалгаагаар түүх соёлын биет өв илэрвэл тухайн олдворын хүрээнд | Үйл ажиллагааны зардлаас |                       | 2024                           | Соёлын өвийг хамгаалах тухай хууль |

### 10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт №26

| Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө   | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ  | Арга хэмжээний цар, хэмжээ                           | Нэгжийн өртөг | Нийт зардал (сая.төг)  | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал                   |
|--|---|--|---------------|--|--------------------------------|--|
| Байгалийн болзошгүй гамшиг, аюулт үзэгдлээс үүдэн төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, дам нөлөөллөөр хүрээлэн буй орчныг бохирдуулах | Цаг агаарын урьдчилсан мэдээлэлд тулгуурлан үйлдвэрлэлийн үйл ажиллагааг байгальд ээлтэйгээр зохицуулах   | Үйлдвэр ажиллах хугацаанд төслийн нийт арга хэмжээнд |               | 2024 оны үйл ажиллагааны болон, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөнд орсон. | Үйл ажиллагааны турш           | Компаний онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөө |
|  | Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах | Төслийн нийт ажиллагсад                              |               | 2024 оны үйл ажиллагааны болон, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөнд орсон. | 2024-2025                      |  |
|  | Хөрсний бохирдол үүсгэх эрсдэлтэй материалын агуулахуудыг гадаргын урсацаас хамгаалах ба тэдгээрээр бодис зөөгдөхөөс хамгаалсан далан шуудуу байгуулах  | Түлш, шатах тослох материал, химийн бодисын агуулах  |               | Үйл ажиллагааны зардалд орно.  |                                | Агуулахыг барьсан даруйд, Үйл ажиллагааны турш |
| Шатах тослох материалын хадгалалт,   | Шатах тослох материалыг стандартын шаардлага хангасан агуулахад хадгалах  | Төсөлд ашиглагдах машин техник                       |               | хийгдсэн   | Жил бүр                        | Химийн хортой ба аюултай бодисын тухай хууль,  |

**Баруун Баруун урт уурхайн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

|   |   |   |  |   |  |
|---|---|---|--|---|--|
| ашиглалтаас хүний эрүүл мэнд ба хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх  | Ажилчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах төлөвлөлтийг хийх, хэрэгжүүлэх   | Нийт ажилчид,   | ХАБЭА-н зардлаас   | Жилд 1 удаа   | холбогдох журам, стандарт<br>Хог хаягдлын тухай хууль  |
|   | Аливаа осол аюулын лавлах мэдээллийн агуулгаар сургалт хийх Монгол улсын Уул уурхайн аврах ангид хандаж сургалт хийнэ   | Нийт ажилчдад   | 2024 оны үйл ажиллагааны болон, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөнд орсон. | Төсөл хэрэгжих хугацаанд Монгол улсын Уул уурхайн аврах ангид хандаж сургалт хийнэ 2023 онд | Химийн хортой ба аюултай бодисын тухай хууль , холбогдох журам, стандарт   |
| Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох   | Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэнд хяналт тавих  | “Хунан” ХХК   | 2024 оны үйл ажиллагааны болон, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөнд орсон. | (Жил бүр)   | MNS4990:2000   |
| Галын аюул:<br>Технологийн үйл ажиллагаанд ашиглагдах химийн бүтээгдэхүүн, бодисууд дотор хялбар шатах, ус орвол тэсрэх дэлбэрэх, гал түймэр гарах аюултай бодисууд их хэмжээтэй ашиглагдаж байгаа нь эрсдэлтэй. Аянга цахилгаан, хэт халалт, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр аюултай химийн бодис тэсэрч дэлбэрэх, галын аюул гарах | Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм журам боловсруулж, түүнийг мөрдөн ажиллах, Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалыг заасан самбар, галын аюул гарах болзошгүй газруудад анхааруулах зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байршуулах, Тэсэрч дэлбэрэх, галын аюултай бодисуудыг нарны гэрлийн шууд тусгалаас хамгаалсан байгууламжид байрлуулах, хамгаалалтын хатуу дэглэм тогтоох, Хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байх, Бүх химийн бодис, ялангуяа шатамхай шингэнийг халаалтын хэрэгсэл, цахилгааны эх үүсвэр, системээс хол, нарны гэрэл шууд тусахааргүй нөхцөлд хадгалах, Аянга зайлуулагчийг шаардлагатай бүх газруудад байрлуулах | Цахилгаан шугам дагуу болон уурхай, үйлдвэрийн талбайд<br>Уурхайн бүс болон хотхонд | 2024 оны үйл ажиллагааны болон, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөнд орсон. | (Жил бүр)   | “Гамшгаас хамгаалах тухай” хууль<br>“Галын аюулгүй байдлын тухай” хууль<br>“Химийн хорт болон аюултай бодисын тухай” хууль |
| Нийт зардал   |   |   | -  |   |  |

**11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө**

Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хуулийн дагуу хог хаягдлыг арилгах ажлыг зохион байгуулна. Хог хаягдлын тухай хуулийн шаардлагуудыг биелүүлж ажиллана.

**А. Ахуйн хог хаягдал**

2024 онд уурхайд 15 хүн ажиллана. Энд НҮБ-аас гаргасан олон улсын судалгаагаар 1 хүнд 430 кг/жил 1.2 кг/хоног ахуйн хатуу хог хаягдал ноогддог байна. Харин улсын нийслэл Улаанбаатар хотод, захирагчийн албаны 2021 оны тайланд дурьдсанаар 1300 кг/жил 3.6 кг/хоног байна.

...Төв суурингаас алслагдсан уурхайн нөхцөлд хүмүүсийн шууд хэрэглэдэг (савлагаатай ундааны зүйлүүд, бусад бэлэн бүтээгдэхүүнүүдийн сав баглаа боодол... зэрэг: хаягдлын 20% эзэлнэ гэж тооцвол) ... зүйлс маш бага байдаг.

Иймд олон улсын жишгийг ишлэн 1 хүний хатуу хог хаягдлыг тооцвол:  $1.2 \text{ кг/хоног} * (100\% - 20\%) = 0.96 \text{ кг/хоног}$  болно.

Эндээс... Уурхай дахь ахуйн хатуу хог хаягдлын хэмжээ:  $15 \text{ хүн} * 181 \text{ хоног} * 0.96 \text{ кг/хоног} = 2606.4 \text{ кг}$  байхаар тооцов.

- Хаягдлын талбайн байршлыг нь хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд нөлөөлөл бага газар сонгон байршуулна.
- Ахуйн хог хаягдлыг багасгах, хянах дотоод журам боловсруулж, хогийг анхан шатанд нь ангилан ялгаж дахин боловсруулдаг зах зээлд нийлүүлнэ.
- Хог хаягдлыг зохистойгоор хаяж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажлын байрны шалгалт тогтмол явуулна.
- Үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах олон боломжит арга аргачлалуудыг баримтлан ажиллана.

Ажилчдын ахуйн хэрэглээнээс үүсэх шингэн хог хаягдал

Уурхайд ажиллах 15 хүний ялгаруулах ахуйн бохирын төслийн тооцоог дараах хүснэгтэд үзүүлэв. БОННУ-с ишлэн тооцов.

| Өгөгдөл   | Хэмжээ    | Шалгуур                                      |
|---|-----------|--|
| Хугацаа   | 180 хоног | Нэг сараар тооцсон                           |
| Хүний тоо   | 15        | 2024 оны УАТ-с авав.                         |
| Хүний нэг өдөрт ялгаруулах өтгөний хэмжээ   | 200гр     | Дэлхийн эрүүл мэндийн газрын гаргасан тооцоо |
| Хүний нэг өдөрт гаргах шингэн хаягдлын хэмжээ   | 15 л      |  |
| Тооцоо: $180 * 15 * 0.2 = 540 \text{ кг}$ ; $180 * 15 * 15 \text{ л} = 40500 \text{ л}$ буюу $40.5 \text{ м}^3$ |           |  |

Энд төвлөрсөн болон бие даасан ариутгах татуургын системд холбох боломжгүй, уурхай нь хүчин чадал бага цөөн хүн ажиллах зэргээс үндэслэн MNS 5924 : 2015 стандартын дагуу ноёлох салхины доод талд  $40.5 \text{ м}^3$  багтаамжтай бордоожуулан хуурайшуулах, газарт бүрэн суулгасан, нэвчилтэй суурийн нүхтэй, нүхэн жорлон, угаадасны нүх байгуулна.

Хатаж хуурайшсан өтгөнийг хатуу хог хаягдалтай хамт эсвэл суллах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан эрх бүхий байгууллагад хандаж зайлуулна.

Б. Уурхай болон баяжуулалтын хог хаягдал

Уурхайн үйл ажиллагааны явцад алтны агуулга багатай хэсэг нь хаягдан байгальдаа үлдэхээс өөр завсрын бүтээгдэхүүн гарахгүй.

Баяжуулалтын үед химийн болон бусад хорт бодис хэрэглэдэггүй тенологийн хорт хаягдал гарахгүй. Харин гравитацийн баяжуулалтаас гарах хаягдал галь, эфил, шлам зэрэг нь тухай бүрийн уулын ажлын үйл ажиллагаатай уялдан уурхайн ухашийн дүүргэлт зэрэг ажилд нөхөн сэргээлтийн технологийн дагуу хэрэглэгдэнэ. Ахуйн болон механизмуудаас гарах хог хаягдал уурхайн тосгонд байгуулсан хогийн цэгт хаягдана.



Уурхайн үйл ажиллагааны улмаас гарсан хаягдал усанд тогтоосон цэгүүдэд хяналтын шинжилгээг тогтмол хийж, төслийн онцлогт тохирсон хүчин чадалтай бохир ус цэвэрлэх байгууламж ашиглан Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS4943:2015 стандартын хүлцэх дээд агууламжид нийцүүлэн цэвэршүүлэх

Энэ ажлын хүрээнд өмнө нь олборлосон нөхөн сэргээгдээгүй ухаш болон нуурыг дахин сэргээж ТЭЗҮ-ний дагуу УАТөлөвлөгөөнд төлөвлөсний дагуу хаягдлын санг байгуулна. Энд гарах зардал нь их биш учир урсгал зардалд орно.

Булингатай ус хуримтлуулах сангийн урт, өргөний хэмжээ 150 \* 96м, гүн нь 3-5м байх 4 бассейн дамжин эргэж байна байна. Хаягдлын сангийн 27 мян.м<sup>3</sup> булинга, тунаах эргэлтийн усан санг 16.3 мян.м<sup>3</sup> MNS6734:2018 стандартад нийцсэн цэвэршүүлсэн ус орохоор эзлэхүүнийг тооцоолсон.

Энд цэвэршүүлсэн усыг дээр дурьдсан тунаах эргэлтийн усан сангаас алттай элсийг гравитацийн аргаар угаан баяжуулалтад дахин ашиглахаас гадна тухайн орон нутгийн малчдын малыг услах, нөхөн сэргээлийн усалгаанд хэрэглэдэг болно. Нэмж дурьдахад уурхайн орчны мал нь худгийн цэвэр усыг уухдаа сайн биш булингатай усыг уухдаа илүү байгаа нь ажиглагдсан ба хордсон гэмтсэн тохиолдууд сүүлийн 5-7 жилд ажиглагдаж мэдэгдээгүй болно.

Мөн **§12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр** хэсэгт... мэргэжлийн байгууллагаар хяналт шинжилгээ хийлгэж дүгнэлт зөвлөмж гаргуулан үйл ажиллагаандаа мөрдөхөөр төлөвлөсөн.

#### В. Аюултай хог хаягдал

Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын хавсралт “Аюултай хог хаягдлын жагсаалт” – д заасан аюулын зэрэглэлээр шууд аюултай хог хаягдал гэж үзэх Ашиглалтаас гарсан машин, механизм, тэдгээрийг задлах болон засварлах үйл ажиллагаанаас үүсэх тосны шүүр, тоормосны шингэн, хар тугалгатай баттерей, аккумуляторын хаягдал.....зэрэг орно

Төслийн үйлвэрлэлийн үйл ажиллагаанд химийн бодис, нэгдэл ашиглахгүй тул үйлдвэрлэлээс аюултай хог хаягдал гарахгүй. Харин төслийн үйл ажиллагаанд ашиглах 8 орчим авто техник, машин механизм, тоног төхөөрөмжөөс тос тосолгооны бүтээгдэхүүнүүд, хаягдал аккумулятор, шүүлтүүрүүд, дугуй, хаягдал төмрүүд... зэрэг гарах бөгөөд тухайн хаягдлыг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2018 оны 1-р сарын 30 ны А/18 дугаар тушаалаар батлагдсан журам болон Хог хаягдлын тухай хуулийн 5-р бүлэг

Аюултай хог хаягдлыг савлах, түр хадгалах, тээвэрлэх, цуглуулах, устгах хуулийн дагуу цуглуулж, тээвэрлэж, аккумулятор дахин боловсруулах үйлдвэрт тушаана.

Манай уурхайн нөхцөлд:

- Хаягдал дугуй... шир. Үүнийг орон нутгийн малчид өвөлжөө хаваржаандаа болон өөрийн уурхайн кемп-ийг тойруулан салхи, цаснаас хамгаалах байгууламж барихад ашигладаг.
- Тосолгооны бүтээгдэхүүнүүд ... кг (л). Үүнийг тус тусад нь зориулалтын сав (бочка)-д авч БО-д хор нөлөөгүй байлгах, осол аюулгүй байдлыг сайтар хангаж хураан хадгалж байгаад Улаанбаатар хот дахь Монгол түлш ХХК-д тушаана.
- Аккумулятор, батарейнууд... шир. Үүнийг УБ хот дахь хоёрдогч түүхий эд боловсруулах газруудад тушаана.
- Түлш, тос, тоосны шүүлтүүрүүд... шир. Үүнийг осол аюулгүй байдлыг сайтар хангаж хоруу чанарыг аргилган хаягдал төмрийн зах зээлд нийлүүлнэ.
- Хаягдал төмөр ... тн. Үүнийг уурхайн засварын цехийн хажууд БО-д сөрөг нөлөөллөлгүйгээр ангилан хэрэглэхийг нь хэрэглэж үлдсэнийг нь төмрийн зах зээлд нийлүүлнэ.

Төслийн хатуу хаягдлын төрөл, шинж чанар, хэмжээ, зайлуулалт, устгал

| Хаягдлын төрөл             | Үүсэх хэмжээ   |      | Хэмжээ<br>х нэгж | Үүсэх хэлбэр   | Төлөв   | Аюултай<br>шинж чанар | Зайлуулах хэлбэр  | Авах шаардлагатай<br>арга хэмжээ   |  |
|----------------------------|--|------|------------------|----------------|---|-----------------------|---|--|--|
|                            | Хоногт   | Жилд |                  |                |   |                       |   |  |  |
| <b>Ахуйн хог хаягдал</b>   |  |      |                  |                |   |                       |   |  |  |
| 1                          | Хуванцар   | -    | 2.61             | тн             | Ажилчдын<br>ахуйн<br>хэрэглээ                       | Хатуу                 | Тодорхойгүй   | -  | -  |
|                            | Хүнсний<br>хаягдал   | -    |                  |                |   | Янз<br>бүрийн         | Холимог   | Дахин ашиглалтгүй<br>хэсгүүдийг сумын<br>төвийн хогийн цэгт<br>зайлуулна | Хаягдал боловсруулах<br>боломжит<br>хувилбаруудыг<br>нэвтрүүлэх  |
|                            | Шил, керамик   | -    |                  |                |   | Хатуу                 | Аюулгүй   |  |  |
|                            | Цаас картон  | -    |                  |                |   | Хатуу                 | Тодорхойгүй   | -  | -  |
|                            | Бусад  | -    |                  |                |   | Хатуу,<br>шингэн      | Холимог   | -  | -  |
| <b>Аюултай хог хаягдал</b> |  |      |                  |                |   |                       |   |  |  |
| 2                          | Ажилласан<br>тос<br>Гидравлик  | -    | 0.1              | тн             | Гидрийн тос   | Шингэн                | Галын аюултай<br>Ургамал,<br>амьтанд<br>хоруу<br>чанартай | -  | Засварын хэсгээс<br>ажилласан тос, хаягдал<br>дугуй ашиглах,<br>боловсруулах<br>дахиварын үйлдвэрт<br>тушаах, УБ хотын БГД<br>-ийн нутагт байрлах<br>“Цэвэр түлш” ХХК, УБ<br>хотын СХД –г<br>байрлах, “Алтан<br>оршихуй” ХХК, “Хай<br>Би Ойл” ХК зэрэг<br>газруудад нийлүүлэх. |
|                            | Хөдөлгүүр,<br>хурдны<br>хайрцаг болон<br>тосолгооны<br>хлор<br>агуулаагүй<br>эрдсийн тос | -    | 0.2              |                | Бүх төрлийн<br>техник<br>хэрэгслийн<br>тос тосолгоо | Шингэн                | Галын аюултай<br>Ургамал,<br>амьтанд<br>хоруу<br>чанартай | -  | -  |
|                            | Хаягдал дугуй  | -    | 20               | ш              | Тээврийн<br>хэрэгслийн<br>засвар<br>үйлчилгээ       | Хатуу                 | Ургамал,<br>амьтанд<br>хоруу<br>чанартай                  | -  | Өөрдөө болон малчид<br>хэрэглэнэ   |
|                            | Хаягдал төмөр  | -    | 1                | тн             | Техникийн<br>засвар<br>үйлчилгээ                    | Хатуу                 | Хөрс<br>бохирдуулна                                       | -  | 2 –дагч түүхий эд<br>боловсруулдаг<br>үйлдвэрт нийлүүлэх   |
|                            | Тосоор<br>бохирдсон<br>хөрс  | -    | -                | м <sup>3</sup> | Тос асгарч,<br>алдагдах                             | Хатуу                 | Хөрс<br>бохирдуулна                                       | -  | Бохирдлыг арилгах<br>боломжит аргуудыг<br>нэвтрүүлэх   |
|                            | Ашигласан<br>аккумулятор   | -    | 3                | ш              | Техникийн<br>засвар<br>үйлчилгээ                    | Холимог               | Амьд биетэд<br>хоруу<br>чанартай                          | -  | -  |
|                            | Тосны шүүр   | -    | 20               | ш              | Техникийн<br>засвар<br>үйлчилгээ                    | Хатуу                 | Амьд биетэд<br>хоруу<br>чанартай                          | -  | Утаагүй шатаах<br>технологитор<br>цэвэрлэгээ эрхлэх  |

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүд

Хүснэгт №27

| №  | Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө  | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ   | Арга хэмжээний цар, хэмжээ                | Нэгжийн өртөг  | Нийт зардал (сая.төг) | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал   |
|----|---|--|---|--|-----------------------|--------------------------------|--|
| 1. | Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын нөлөөгөөр хөрс, ус, агаар бохирдох, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх | Орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулж ажиллах  | Төслөөс гарах хог хаягдал                 | 1.600  |                       | 2024                           | Хог хаягдлын тухай хуулийн 9-р зүйл                                      |
| 2  |   | Төслийн талбайд үүссэн бүх хатуу хог хаягдлыг цуглуулах нэгдсэн цэгт хүргэж, зайлуулж байх   | Төслөөс гарах хог хаягдал                 | Үйл ажиллагааны зардлаас   |                       | 2024                           | Хог хаягдлын тухай хууль   |
| 3  |   | Хог хаягдлыг цуглуулах савыг стандартын шаардлага хангасан битүүмж сайтай хийх, ажилчдын байр, оффис, агуулах, ШТС зэрэг газарт байрлуулах, ариутгал, тогтмол засварлаж байх | Төслийн хүрээнд                           | Үйл ажиллагааны зардлаас   |                       | 2024                           | Хог хаягдлын тухай хуулийн 11-р зүйл                                     |
| 4  |   | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх  | Төслийн хүрээнд                           | Үйл ажиллагааны зардлаас   |                       | 2024                           |  |
| 5  |   |  |   |  |                       |                                |  |
| 6  |   | Хийсч тархсан болон үүссэн хог хаягдлын овоолгыг тогтмол цэвэрлэж хэвших   | Ашиглалтын талбай болон түүний ойр орчимд | Үйл ажиллагааны зардлаас   |                       | Сар улирлаар, 2023             |  |
| 7  |   | Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх  | Төслийн хэмжээнд                          | Үйл ажиллагааны зардлаас   |                       | 2024                           | Хог хаягдлыг тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017-05-12 MNS 5924:2015 |
| 8  |   | Уурхайн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа нүхэн жорлонг MNS 5924:2015 стандартын шаардлага хангасан болгох. Мөн сар бүр ариутгаж байх.                                       | Төслийн хэмжээнд                          | Үйл ажиллагааны зардлаас   |                       | Жил бүр /сар бүр/              |  |
| 9  |   | Ахуйн гаралтай хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, түр хогийн цэгт цуглуулах ба дахин ашиглагдах боломжтой хэсгийг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх                       | Төслийн хэмжээнд                          | Үйл ажиллагааны зардал /Хог хаягдлыг хадгалах, устгах, тээвэрлэх эрх бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээлэн ажиллах/ |                       | Жил бүр Улиралд нэг удаа       |  |
|    | Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж,   | Төслийн хэмжээнд   | Үйл ажиллагааны зардлаас                  |  | 2024                  |                                |  |

|                    |   |                  |  |  |                          |
|--------------------|---|------------------|--|--|--------------------------|
|                    | зориулалтын саванд түр цуглуулах  |                  |  |  |                          |
|                    | Аюултай хог хаягдлыг ашиглалтын талбайд цуглуулж жилд нэг удаа дахин боловсруулах үйлдвэрлүү тээвэрлэж байх.  | Төслийн хэмжээнд |  | Үйл ажиллагааны зардал /Аюултай хог хаягдлыг хадгалах, устгах, тээвэрлэх эрх бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээлэн ажиллах/ | Жил бүр Улиралд нэг удаа |
|                    | Үйл ажиллагааны явцад гарсан аюултай хог хаягдлыг ангилан ялгах, хадгалах, устгах, зайлуулах БОННУ-ий /4.1 болон 3.12 дүгээр бүлэгт заасан зөвлөмжийг мөрдөж ажиллах/ | Төслийн хэмжээнд |  |  |                          |
| <b>Нийт зардал</b> |   |                  |  | <b>1.6</b>   |                          |

## 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, төсөл хэрэгжих орчинд амьдардаг, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн амьжиргаа, нийгмийн болон эрүүл мэндийн байдлыг илтгэх гол үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамжийг тодорхойлон оруулж төлөвлөв.

Орчны хяналт шинжилгээг мэргэжлийн байгууллагатай гэрээ хийж гүйцэтгүүлнэ.

Төслийг хэрэгжүүлэхэд баримтлан ажиллах орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр нь төсөл хэрэгжих орчны олон талт үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа, хяналтын байгууллагад бодитой мэдээлэл өгөх зорилготой.

Жил бүр тухайн жилд хийгдсэн хяналт-шинжилгээний үзүүлэлтүүдийг судалж байх нь цаашид байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсронгуй болгох, байгаль орчин болон тухайн нутагт амьдардаг иргэдийг сөрөг нөлөөллөөс хамгаалах арга хэмжээг илүү үндэслэлтэй болгох юм.

Ил уурхайн олборлолт, баяжуулах хэсэг болон тээвэрлэлтийн үйл ажиллагааны жил бүрийн хяналт-шинжилгээний ажлын үр дүнг нутгийн иргэдэд мэдээлж, хяналт-шинжилгээний ажлыг төлөвлөж хэрэгжүүлэхдээ нутгийн иргэдийн санал бодлыг тусгаж, нутгийн иргэдийн оролцоог хангаж ажиллах нь зүйтэй. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг дараах хүснэгтэд-27-д үзүүлэв.

### Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөлт

Хүснэгт №27

| №  | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд  | Байршил  | Хугацаа ба давтамж | Хяналт шинжилгээний ажлын хэмжээ                 | Нэгжийн өртөг сая.төг | Нийт зардал, сая.төг | Баримтлах стандарт ба арга, аргачлал            | Дээд доод хязгаар   |
|--|--|--|--------------------|--|-----------------------|----------------------|---|---|
| <b>1. АГААРЫН ЧАНАР</b>                  |  |  |                    |  |                       |                      |   |   |
| 1  | Агаар дахь тоосжилтын хяналт:<br>Нийт тоос (TSP),<br>PM2.5, PM10<br>Тоосны уналт | - Элс угаах төхөөрөмжийн орчимд,<br>- Замын хажууд | Жилд 1 удаа        | Тоосжилтын хяналтын явуулах мониторингийн 2 цэгт | -                     | 1.0                  | MNS 4585:2007<br>MNS:3384:1982<br>MNS:4048:1988 | PM <sub>2.5</sub> -<br>0.05<br>мг/м <sup>3</sup><br>PM10-<br>0.1мг/м <sup>3</sup> |
| <b>2. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УС</b> |  |  |                    |  |                       |                      |   |   |

**Баруун Баруун урт уурхайн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

|                            |  |  |                   |   |   |      |  |     |
|----------------------------|--|--|-------------------|---|---|------|--|-----|
| 2                          | Гадаргын болон газрын доорх усны чанар:<br>Гол ионы найрлага :<br>Усны түвшин, рН, өнгө, булингаршил, хуурай үлдэгдэл, эрдэсжилт, нийт хатуулаг, | - Ус ашиглах технологийн дамжлагын үе шат бүр дээр,/тунгаах нуур/<br>- Төслийн талбай орчмын уст цэг<br>- Ундны усны эх үүсврийн худаг                         | Жилд 1 удаа       | Нийт 3 цэг дээр дээжлэлт хийж шинжлэх               | - | 1.4  | MNS 3934:1986 - ундны болон үйлдвэрлэлийн хэрэгцээт усны химийн шинжилгээ болон дээж авах, хадгалах;<br>MNS (ISO) 5667-5:2001- усны чанар- дээжлэлт MNS 900-2010 MNS 6148;2010 MNS 4586 : 1998 | ЗДХ |
| <b>3. ХӨРСӨН БҮРХЭВЧ</b>   |  |  |                   |   |   |      |  |     |
| 3                          | Ялзмагийн агууламж, рН, давсжилт, чийгшил, NO3-N, P2O5, K2O, рН, нийт азот, нийт фосфор,   | - Нөлөөлөлд өртөөгүй талбай<br>- Нөхөн сэргээлт хийгдсэн талбай,<br>- Шимт хөрсний овоолго   | Жилд 1 удаа       | Уурхайн бүсийн орчим мониторингийн 3ш тогтмол цэгт  | - | 0.8  |  | ЗДХ |
|                            | Нефть, нефтийн бүтээгдэхүүн, нүүрсустөрөгчид, хүнд металлын агууламж микробиологийн үзүүлэлт   | - Шатахуун ачих, буулгах, машин механизмыг шатахуунаар цэнэглэх талбай, агуулах орчимд<br>- Элс угаах төхөөрөмжийн орчимд,<br>- Хог хаягдал бохирын цэг орчимд | Жилд 1 удаа тутам | Уурхайн бүсийн орчим мониторингийн 3 ш тогтмол цэгт | - | 0.2  | MNS5850 : 2008   | ЗДХ |
| <b>4. УРГАМАЛАН НӨМРӨГ</b> |  |  |                   |   |   |      |  |     |
| 4                          | Ургамлын төрөл зүйл, бүрхэц %, Ургамлын дундаж өндөр, Газрын гадаргуугаас дээшхи ургамлын биомасс, кг/га;  | - Нийт тусгай зөвшөөрөл бүхий талбайд  | Жилд 1 удаа       | Ургамлын хяналт шинжилгээг мониторингийн 3-5 цэгт   | - | 0.05 | Батлагдсан арга зүйн дагуу   | -   |
| <b>5. АМЬТЫН АЙМАГ</b>     |  |  |                   |   |   |      |  |     |

|  |  |  |             |  |   |            |                            |      |
|--|--|--|-------------|--|---|------------|----------------------------|------|
| 5                                      | Амьтны төрөл зүйл, тоо толгой, шилжилт хөдөлгөөн | - Нийт тусгай зөвшөөрөл бүхий талбайд                        | Жилд 1 удаа | Амьтны аймгийн судалгааг төсөл хэрэгжиж буй газар нутгийн орчимд | - | 0.05       | Батлагдсан арга зүйн дагуу |      |
| <b>6. ДУУ ЧИМЭЭ БА ДОРГИО ЧИЧИРГЭЭ</b> |  |  |             |  |   |            |                            |      |
| 6                                      | Гадаад орчны дуу чимээ                           | - Нийт тусгай зөвшөөрөл бүхий талбайд<br>- Ил уурхайн орчимд | Жилд 1 удаа | Хяналт шинжилгээ явуулах 2 мониторингийн цэг дээр                | - | 0.1        | MNS 4585:2007              | 60дБ |
|  | Ажлын байрны дуу, чимээ                          | - Ил уурхайн орчимд,<br>- Элс угаах төхөөрөмжийн орчимд      | Жилд 1 удаа | Шаардлагатай ажлын байрнууд дээр                                 | - | 0.1        |                            | 85дБ |
| <b>Бүгд</b>                            |  |  |             |  |   | <b>3.8</b> |                            |      |

### 13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Баруун урт ордыг ашиглах төслийн ТЭЗҮ, Уулын ажлын төлөвлөгөө, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж энэ чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож ажиллана.

Уурхайн хүчин чадал бага тул удирдлагын нүсэр бүтэц байх шаардлагагүй байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг компаний захирал уурхайн дарга, инженерүүд, ээлжийн мастер ахлагч хариуцан гүйцэтгэх бөгөөд жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж ажиллана.

Нөхөн сэргээлт болон байгаль орчныг хамгаалах ажлыг урьдчилан төлөвлөсний дагуу дэс дараалалтай хийж гүйцэтгэх бөгөөд нөхөн сэргээлт хийж дууссан талбайг орон нутгийн захиргаанд хүлээлгэн өгнө. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийлгэсэн дүнг холбогдох байгууллагад хүргэж тайлагнах.

Компанийн удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль журмын дагуу уурхайн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ.

### Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал

Хүснэгт №28

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ   | Хугацаа, давтамж                            | Зардал. Сая төг | Баримтлах хууль журам, стандарт  |
|---|--|---|-----------------|----------------------------------|
| 1 | Байгаль орчны асуудлыг удирдлагын түвшний ажилтанд хариуцуулж, хяналт тавин ажиллах; | Төсөл хэрэгжих нийт хугацаанд               | 0.2             | “Байгаль хамгаалах тухай” хууль  |
| 2 | Газрын төлөв байдал, улсын чанарын хянан баталгааны ажил хийлгэх                     | Төсөл хэрэгжих нийт хугацаанд 5 жил дутамад | хийгдсэн        |                                  |
| 3 | Байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх;                              | 2021  | хийгдсэн        | “Байгаль орчныг хамгаалах тухай” |

|             |  |                               |                        |   |
|-------------|--|-------------------------------|------------------------|---|
|             | Гарсан дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах;                 |                               |                        | хуулийн 10.1 –дэх заалт; БОНХС-ын 2013 оны А-126 тоот тушаал; |
| 4           | Ажилтнуудад байгаль орчны сургалтуудыг ажлын байранд нь зохион байгуулж, | Төсөл хэрэгжих нийт хугацаанд | Үйл ажиллагааны зардал | -   |
| 5           | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба тайлан боловсруулах             | Төсөл хэрэгжих нийт хугацаанд | 0.3                    | БОНБУ-ний тухай хууль   |
| Нийт зардал |  |                               | <b>0.5</b>             |   |

#### 14. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч “Хунан” ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар орон нутгийн байгаль орчин аялал жуулчлалын газар, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, сум багийн засаг даргын тамгын газар, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж оролцоно..

Төсөл хэрэгжүүлэгч “Хунан” ХХК нутаг дэвсгэрийн сум, багийн иргэдийн хуралд БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг жил тутамд хийнэ. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөг хүснэгт №29-д үзүүлэв.

Хүснэгт №29

| БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд |                                       | Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр                                  | Мэдээллийн агуулга                                 | Хугацааны тов         | Хэлэлцүүлгээр санал авах чиглэл                          | зардал     | Зохион байгуулах газар |
|--|---------------------------------------|--|--|-----------------------|--|------------|------------------------|
| Төв аймаг  | Байгаль орчин, аялал жуулчлалын газар | Тайлан хүргүүлэх, ажлын хэсэгт нөхөн сэргээлтээ хүлээлгэн өгөх | БОМТ-ийн тухайн жилийн тайлан, Ирэх оны төлөвлөгөө | 11-р сард             | Дүгнэлт гаргуулах  | 0.25       | Төслийн талбай, уурхай |
| Сэргэлэн сум   | Багийн ИНХ                            | Танилцуулах  |  | 5-р сард              | БОХ арга хэмжээний төсөл дээр санал авах хамтран ажиллах | 0.25       | Багийн төв             |
|  | Сумын ЗД, БОХХ Байцаагч               | Уулзалт  |  | 10-р сард<br>5-р сард |  |            | Сумын төв              |
| Төрийн захиргааны төв байгууллага                      | БОАЖЯ-ны ХБОБНУГ                      | Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр болон Файл хэлбэрээр      | Уулын ажлын төлөвлөгөө батлагдсаны дараа           | Хянуулан батлуулах    | -  | УБ хот     |                        |
| <b>Нийт зардал</b>                                     |                                       |  |  |                       |  | <b>0.5</b> |                        |

Нэг. Төсөл хэрэгжүүлэгч “Эрдэнэ Дорно” ХХК, төслийн товч мэдээлэл

хүснэгт №31

| д/д  | Мэдээллийн төрөл   | Утга  |
|--|--|---|
| 1.1  | 1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэр   | “Хунан” ХХК   |
|  | 2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар (регистрийн дугаар)  | 1411001082<br>(РД: 2549204)   |
|  | 3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл   | Алт олборлолт   |
|  | 4. Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг  | БГД дүүрэг 20- хороо Өнөр хотхон 39-194   |
|  | 5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг   | Х.Бат-Эрдэнэ, утас: 99118411, 91913769,<br>erdenedorno_2020@yahoo.com   |
|  | 6. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг   | Уурхайн менежер Б.Сувдаа, утас: 99065956<br>Уул уурхайн инженер С.Ганбат утас: 94014243<br>Sganbat.44@gbail.com |
| 1.2  | 1. Төслийн нэр   | “Баруун Баруун урт” ордын 2024 оны ашиглалтын үйл ажиллагаа   |
|  | 2. Төслийн харьяаллын байршил  | Төв аймаг Сэргэлэн сум 1-р баг Баруун уртын эх  |
|  | 3. Төслийн ангилал   | -   |
|  | а. нүүрс, алт, жонш, төмрийн хүдэр гэх мэт   | алт   |
|  | б. ил уурхай, далд уурхай, шороон орд  | ил уурхай   |
|  | в. Баяжуулах   | гравитацаар   |
|  | 4. Төсөл эхэлэх огноо  | 2024 оны 04-р сар   |
|  | 5. Төсөл хэрэгжих хугацаа  | 2025 оны 01-р сар хүртэл  |
|  | 6. Уурхайн хаалт эхлэх огноо   | 2026 он   |
|  | 7. Хаалтын дараах зориулалт  | бэлчээр   |
|  | 8. ГЭЗҮ баталсан огноо   | 2020  |
|  | 9. Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ (дунджаар)  | 30 мян.м <sup>3</sup>   |
| 10. Ажилчдын тоо   | 15   |   |
| 11. 2024 оны ажлын ерөнхий төлөвлөгөө (Үйлдвэрлэлийн нөөцөөр)  | 3.51 мян.м <sup>3</sup> хөрс хуулж, 62.383 мян.м <sup>3</sup> элс олборлоход 3.3353 га талбай эвдэгдэнэ. 4 га-д техникийн, 4 га-д биологийн нөхөн сэргээлт. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ 0 га, өссөн дүнгээр 8 га-д БО-ны нөхөн сэргээлт хийнэ. |   |
| 12. Тухайн төсөлд хамаарагдах дэд бүтэц<br>- замын урт<br>- шатахуун түгээгүүрийн тоо<br>-шатахуун агуулахын агууламжийн хэмжээ<br>- тэслэх, дэлбэлэх бодисын үйлдвэрийн хүчин чадал г.м | -<br>Уурхайн замын нийт урт 2 км<br>1<br>25тн<br>Хамаарахгүй   |   |

Мэдээллийг гаргасан: С.Ганбат Уул уурхайн инженер. /С.Ганбат/



Хоёр. Төсөл хэрэгжүүлэх чиглэлээр олгодог тугай зөвшөөрөл, дүгнэлт, лавлагааны  
товч мэдээлэл

хүснэгт №32

| д/д   | Мэдээллийн төрөл  |  | Утга  |     |
|---|---|--|---|-----|
| 2.1   | 1. Тусгай зөвшөөрлийн төрөл /ашигт малтмал/<br>дугаар<br>хүчинтэй хугацаа<br>талбай             |  | Ашигт малтмал ашиглах<br>MV-08097<br>30 жил<br>77.48 га |     |
|   | 2. Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах/<br>Дугаар хүчинтэй хугацаа                   |  | хамаарахгүй   |     |
|   | 3. Химийн бодисын агуулахад хийсэн мэргэжлийн<br>хяналтын газрын тодорхойлолт                   |  | хамаарахгүй   |     |
|   | 4. Галын дүгнэлтийн огноо, дугаар   |  | -   |     |
|   | 5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий<br>үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд         |  | 2020-10-07<br>13/6780<br>БОАЖЯ-ны шинжээч Д.Батмөнх     |     |
|   | 6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан<br>үнэлгээний огноо,<br>баталсан хуулийн этгээд |  | 2021<br>БОАЖЯ-ны ерөнхий шинжээч<br>Ч.Батсансар         |     |
|   | 7. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо   |  | 2024  |     |
|   | 8. Тухайн жилийн уулын ажлын батлагдсан<br>төлөвлөгөөний огноо                                  |  | 2024  |     |
|   | 9. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 1.5, 1.7,<br>1.9, 1.10, 1.11 дэх маягтыг хавсаргах |  |   |     |
|   | 10.Нөхөн<br>сэргээлт  | Техникийн нөхөн<br>сэргээлтийн<br>талбай /га-аар/  | тайлант онд<br>гүйцэтгэсэн                              | -   |
|   |   |  | төлөвлөгөөт онд<br>гүйцэтгэх                            | 4.0 |
|   |   | Биологийн нөхөн<br>сэргээлтийн<br>талбай<br>/га-аар/   | тайлант онд<br>гүйцэтгэсэн                              | -   |
| төлөвлөгөөт онд<br>гүйцэтгэх  |   |  | 4.0   |     |
| 11. ТХГН-ийн тухай хууль, Гол, мөрний урсац<br>бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс,<br>ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг<br>хориглох тухай хуулиар тогтоосон хамгаалалтын<br>бүсийн хилийн заагтай давхацсан эсэхийг<br>тодорхойлсон лавлагааг хаьсаргах |   | Лавлагаа гаргуусан   |   |     |
| 12. Тухайн жилд баримтлах стандартын дугаар<br>-үндэсний<br>-олон улсын   |   | MNS5914:2008, MNS 5915:2008,<br>MNS 5916:2008, MNS 5917:2008,<br>MNS 5918:2008, MNS 3298-90<br>MNS4048-88, MNS 0012-013-91, MNS<br>5080-2001 гэх мэт |   |     |

Мэдээллийг гаргасан: *С.Ганбат* Уул уурхайн инженер. /С.Ганбат/

Гурав. Химийн бодисын эрсдэл, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

хүснэгт №33

| д/д | Мэдээллийн төрөл  | Утга                                 |
|-----|---|--------------------------------------|
| 3.1 | 1. Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ /кг/  | хамаарахгүй                          |
|     | 2. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө   | хамаарахгүй                          |
| 3.2 | 1. Шатах тослох материалын нэр хэмжээ /тн/ агуулах байгаа эсэх  | 25 тн-ын 1 агуулахтай<br>хамаарахгүй |
|     | 2. Тэслэх, дэлбэлэх бодисын нэр хэмжээ /кг/ агуулах байгаа эсэх   |                                      |
| 3.3 | 1. Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /кг/<br>- Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/<br>- Үйлдвэрийн хог хаягдал /хатуу, шингэн/<br>- Аюултай хог хаягдал | 500<br>150<br>-<br>хамаарахгүй       |
|     | 2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв. мян.төг.   | 650.0 мян.төгрөг                     |

Дөрөв. Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний тухайн жилийн төсөв

Доорх хүснэгтийн 4.1.2-4.1.7-д тусгагдсан тухайн жилийн арга хэмжээний төсвийн нийлбэр нь 4.1.1-д тусгагдана.

хүснэгт №34

| д/д   | Мэдээллийн төрөл  | Утга<br>мян.<br>төг. |
|---|---|----------------------|
| 4.1   | А. Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв  | <b>26908</b>         |
|   | 1. Нөлөөллийг бууруулах урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээний төсөв /технологийн зөв шийдэл/                  | 1400                 |
|   | 2. Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв /техникийн, биологийн/  | 15108                |
|   | 3. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төсөв  | Урсгал зардалд орно. |
|   | 4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө   | -                    |
|   | 5. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв   | -                    |
|   | 6. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө   | -                    |
|   | 7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө  | 600                  |
|   | 8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв | 500                  |
|   | 9. Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв  | 3800                 |
| 10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв | 500   |                      |
| 5   | 11. “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих мод (1 га-д 500 шир. мод)  | 5000                 |

“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих мод (1 га-д 500 шир. мод)... энэ ажлын хүрээнд орон нутагтай зөвшилцөж тухайн үе шатанд хамтран ажиллаж гүйцэтгэнэ.

Тав. Мета мэдээлэл

